



ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ЧАНАРЫН СУДАЛГАА

Эцсийн тайлан



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй аливаа шударга бус байдлыг таслан зогсоохын төлөө тэмцдэг НҮБ-ын манлайлагч байгууллага юм. Дэлхийн 170 улс орны мэргэшсэн зөвлөхүүд, түншүүдийн өргөн сүлжээтэй хамтран ажиллаж хүн төрөлхтөн хийгээд эх дэлхийнхээ сайн сайхны төлөө нэгдсэн, баталгаатай, тогтвортой хэрэгжих гарц шийдлийг олоход нь улс үндэстнүүдэд тусалж байдаг.

НҮБХХ-ийн Хурдасгуур Лаборатори нь 116 орныг хамарсан 92 лабораторийн сүлжээ юм. “Сонирхолтой бөгөөд хурдан” гэсэн уриатай Хурдасгуур Лаборатори нь хамтрагч байгууллагуудад хөгжлийн асуудлыг шинэлэг өнцгөөс харах, судалгаа шинжилгээ, туршилт хийх шинэ чадавхийг бүрдүүлэн, харилцан уялдаатай, үр нөлөөтэй шийдлүүдийг олохоор ажиллаж байна.

Ерөнхий зүйл:

Энэхүү тайлагийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурь, зөвшөөрлийг илэрхийлээгүй. НҮБХХ энэхүү тайланд гарсан тоо баримтын үнэн зөв эсэхийг баталгаажуулахгүй бөгөөд тоо баримтыг ашигласанаар гарах үр дагаварыг хариуцахгүй. НҮБХХ-ийг тодорхой дурдсан тохиолдолд хувийн болон ашгийн бус зорилгоор энэхүү бүтээлээс иш татаж буюу хэсэгчлэн хуулбарлан ашиглаж болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

© 2021 United Nations Development Programme.

Зохиогчийн бүх эрхийг хамгаалсан. 2021 оны хэвлэл.

Судалгааны баг: Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)

Зохиогчид:

Д. Болор-Эрдэнэ¹, Т. Азбилэг², Г. Долгорсүрэн³, А. Очбадрал⁴

Цахим хувилбарыг авах холбоос:

<http://mn.undp.org>

Холбоо барих хаяг:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр

НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гудамж 14,

Сүхбаатар дүүрэг, 14201, Улаанбаатар хот,

Утас: +976-11-327585

1 IRIM судалгааны хүрээлэнгийн Зөвлөх
2 IRIM судалгааны хүрээлэнгийн Инновац, технологийн менежер
3 IRIM судалгааны хүрээлэнгийн Судлаач, зохицуулагч
4 IRIM судалгааны хүрээлэнгийн Дата менежер



ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэргэдэх Хурдасгуур Лаборатори нэгжийн захиалгаар IRIM судалгааны хүрээлэн 2021 оны 5 дугаар сарын 26-аас 2021 оны 8 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэв. Судалгааны ажлыг гүйцэтгэхэд техник, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Хурдасгуур Лабораторийн нэгжийн төлөөлөл Л.Булган (Head of Experimentation), Т.Алдарсайхан (Head of Exploration), Ж.Санчир (Head of Solutions Mapping) нарт гүн талархлаа илэрхийлье.

Түүнчлэн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нийгмийн ажилтан, зохион байгуулагч нар, судалгаанд хамрагдаж өөрсдийн цахим ур чадвартай холбоотой асуудлаар санаа бодлоо хуваалцаж, мэдээлэл өгсөн зорилтот бүлгийн иргэддээ талархлаа илэрхийлж байна.

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	I
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	III
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	IV
ХУРААНГУЙ	1
1 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	5
1.1. Судалгааны зорилго	5
1.2. Арга зүйн хүрээ	5
1.3. Судалгааны хязгаарлагдмал талууд, ижил төстэй судалгааны ажил гүйцэтгэхэд өгөх зөвлөмж	5
1.4. Түүврийн хүрээ ба стратеги	7
2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР	9
2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүйн үзүүлэлт	10
2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим хүртээмжийн байдал	10
2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар	12
2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ	16
3. АХМАД НАСТАЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР	17
3.1. Ахмад настай иргэдийн хүн ам зүйн үзүүлэлт	18
3.2. Ахмад настай иргэдийн цахим хүртээмжийн байдал	18
3.3. Ахмад настай иргэдийн цахим ур чадвар	19
3.4. Ахмад настай иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ	23
4. АЛСЛАГДСАН БҮСЭД СУУРЬШИЖ БУЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР	24
4.1. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд	25
4.2. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим хүртээмжтэй байдал	25
4.3. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим ур чадвар	26
4.4. Алслагдмал бүсэд суурьшдаг иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ	31
5. ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР	32
5.1. Шилжин ирэгчдийн хүн ам зүйн үзүүлэлт	33
5.2. Шилжин ирэгчдийн цахим хүртээмжийн байдал	34
5.3. Шилжин ирэгчдийн цахим ур чадвар	37
5.4. Шилжин ирэгчдийн цахим цахим ур чадварын хэрэгцээ	38
6. АМЬЖИРГААНЫ БАТАЛГААЖИХ ТҮВШИНГЭЭС ДООГУУР ОРЛОГОТОЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР	39
6.1. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд	40
6.2. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн цахим хүртээмжийн байдал	40
6.3. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн цахим ур чадвар	40
6.4. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ	44
СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ	45
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	46
ХАВСРАЛТ	47
ХАВСРАЛТ 1. Оролцогчдыг сонгох шалгуур үзүүлэлт	47
ХАВСРАЛТ 2. Судалгаанд хамруулсан ХБИ-ийн бэрхшээлийн төрөл, үндэслэл, судалгаа авах аргачлал	48
ХАВСРАЛТ 3. Хүн ам зүйн мэдээлэл/зорилтот бүлгээр/	49
ХАВСРАЛТ 4. Өрхийн утас, компьютерийн хүрэлцээ /зорилтот бүлгээр/	50
ХАВСРАЛТ 5. Өрхийн утас, компьютерийн хүрэлцээ /зорилтот бүлгээр/	51
ХАВСРАЛТ 6. Өрхийн интернэтийн хүртээмж болон хэрэглээ /зорилтот бүлгээр/	52

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ур чадвар тус бүрээр, 1-4 хүртэлх онооноос	2
Хүснэгт 2. Цахим ур чадварын хүрээ, хэрэглэгдэхүүний бүрэлдэхүүн хэсгүүд	5
Хүснэгт 3. Хүн ам зүйн мэдээлэл/зорилтот бүлгээр/	7
Хүснэгт 4. ХБИ-ийн интернэт, компьютер, гар утастай холбоотой чадварын хэрэгцээ	16
Хүснэгт 5. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн интернэтийн хэрэглээ	23
Хүснэгт 6. Алслагдсан бүсэд суурьшдаг өрхүүдэд гар утас, интернэт, нийгмийн сүлжээ ашиглах тулгардаг нийтлэг бэрхшээлүүд	25
Хүснэгт 7. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн интернэт, компьютер, гар утастай холбоотой чадваруудын ач холбогдол, өөрсдийн үнэлгээгээр	30
Хүснэгт 8. Интернэтийн хэрэглээ	31
Хүснэгт 9. Түгээмэл ашиглаж буй аппликэйшн болон хэрэглээ	33
Хүснэгт 10. Шилжин ирэгч хувьд хэрэгцээтэй байгаа цахим ур чадварууд	34
Хүснэгт 11. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувьд хэрэгцээтэй байгаа цахим ур чадварууд	38
Хүснэгт 12. Ахмад настай иргэдийн хувьд хэрэгцээтэй байгаа цахим ур чадварууд	44
Хүснэгт 13. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ур чадвар тус бүрээр, 1-4 хүртэлх онооноос	45

Зургийн жагсаалт

Зураг 1. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ДижКомп аргачлалын хүрээгээр	2
Зураг 2. Өрхийн сарын дундаж орлого /зорилтот бүлгээр/	8
Зураг 3. Сарын харилцаа холбоо болон интернэтэд зарцуулдаг дундаж зардал /зорилтот бүлгээр/	8
Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварын нэгдсэн үр дүн	12
Зураг 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хайж олох ур чадвар	12
Зураг 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	13
Зураг 7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим контент бүтээх ур чадвар	14
Зураг 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар	15
Зураг 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар	15
Зураг 10. Ахмад настай иргэдийн цахим ур чадварын нэгдсэн үр дүн	19
Зураг 11. Ахмад настай иргэдийн мэдээлэл хайж олох ур чадвар	19
Зураг 12. Ахмад настай иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	20
Зураг 13. Ахмад настай иргэдийн цахим контент бүтээх ур чадвар	21
Зураг 14. Ахмад настай иргэдийн цахим аюулгүй байдлаа хангах ур чадвар	21
Зураг 15. Ахмад настай иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар	22
Зураг 16. Цахим хэрэглээтэй холбоотой үүсдэг асуудлыг шийдвэрлэлт	22
Зураг 17. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим ур чадвар	26
Зураг 18. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн мэдээлэл хайж олох ур чадвар	27
Зураг 19. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	28
Зураг 20. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим контент бүтээх ур чадвар	29
Зураг 21. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар	29
Зураг 22. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар	30
Зураг 23. Шилжин ирэгчдийн цахим ур чадвар	35
Зураг 24. Шилжин ирэгчдийн мэдээлэл хайх, олж авах ур чадвар	35
Зураг 25. Шилжин ирэгчдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	36
Зураг 26. Шилжин ирэгчдийн цахим контент бүтээх ур чадвар	36
Зураг 27. Шилжин ирэгчдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар	37
Зураг 28. Шилжин ирэгчдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар	37
Зураг 29. Цахим хэрэглээтэй холбоотой үүсдэг асуудлыг шийдвэрлэлт	38
Зураг 30. Ахмад настай иргэдийн мэдээлэл хайж олох ур чадвар	40
Зураг 31. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн цахим ур чадвар	41
Зураг 32. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн мэдээлэл хайх, олж авах ур чадвар	41
Зураг 33. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	42
Зураг 34. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар	43
Зураг 35. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар	43
Зураг 36. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ДижКомп аргачлалын хүрээгээр	45

ХУРААНГУЙ

Дэлхий нийтээр цахим шилжилтийг эрчимтэй хэрэгжүүлж байгаа энэ үед Монгол Улсын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үйлчилгээгээ цахим хэлбэрт шилжүүлэх, санал болгох нь нэмэгдсээр байна. Үүний тод жишээ нь 2020-2021 онд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас төрийн 50 орчим байгууллагын 527 үйлчилгээг цахимжуулж, и-Монголиа системд нэгтгээд байна⁵. Гэвч энэхүү цаг үе, нийгмийн хөгжлийг дагасан цахим шилжилтэд иргэд, олон нийтийн бэлэн байдал, цахим орчинд ажиллах мэдлэг, ур чадварыг үнэлсэн судалгаа, шинжилгээний ажил хараахан гараагүй, арга зүйн хүрээнд хөгжүүлэлтийн шатандаа явсаар байна. Ийм учраас IRIM судалгааны хүрээлэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Хурдасгуур Лабораторийн захиалгаар “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”-г 2021 оны 5 дугаар сарын 26-аас 8 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Судалгааны хүрээнд (1) ахмад настай иргэд, (2) хөгжлийн бэрхшээлтэй иргэд (3) амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд, (4) шилжин суурьшсан өрх, (5) алслагдмал бүсэд амьдардаг өрх гэсэн 5 зорилтот бүлгийн төлөөллийн 78 оролцогчтой ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж, эдгээр бүлгийн иргэд тус бүрийг оролцуулсан 5 удаагийн бүлгийн ярилцлагыг хийж, нийт 114 хүнийг хамрууллаа. Мэдээлэл цуглуулалтыг Улаанбаатар хотын захын 4 дүүрэгт зохион байгуулсан.

Эдгээр зорилтот бүлгүүдийн цахим ур чадварыг үнэлэхдээ Европын Холбооны ДижКомп⁶ олон улсын стандартад тулгуурлан дараах 5-н үзүүлэлтээр үнэлсэн. Үүнд:

- Мэдээлэл хайх, олж авах ур чадвар;
- Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар;
- Цахим контент бүтээх ур чадвар;
- Аюулгүй байдлаа хангах ур чадвар;
- Асуудлыг шийдвэрлэх ур чадвар

Эдгээр чадваруудыг үнэлэхдээ ур чадвар тус бүрийг илтгэх шалгуур асуултуудад оролцогчийн өөрийн үнэлгээг авахаас гадна тухайн ур чадварыг илтгэх зохих түвшний даалгавруудыг гүйцэтгүүлэн, бодит үйлдэлд нь хийсэн ажиглалтын үнэлгээг нэгтгэн тооцсон. Ур чадварыг илтгэх асуулт бүрийг 1-4 хүртэлх “шкал”-аар хэмжиж тэдгээрийн дундаж үнэлгээгээр ур чадвар бүрийн эцсийн үнэлгээг тооцов.


Судалгааны үр дүнг нэгтгэн танилцуулбал хүртээмжийн хувьд зорилтот таван бүлэгт гар утас, компьютерийн хүртээмж цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ авах зэрэг өөрсдийн хэрэгцээг хангахад хангалтгүй байна. Дийлэнх өрхийн гишүүд бүгд гар утастай ч ухаалаг төхөөрөмж худалдаж авах санхүүгийн боломжгүй байдлаас шалтгаалан товчлууртай утасны хэрэглээ өндөр байна. Түүнчлэн гэртээ компьютертэй айл маш цөөн, интернэт холбогдолт бага, ихэвчлэн шаардлагатай үедээ утсаараа дата авч интернэт ашиглаж байгаа зэрэг нь зорилтот бүлгүүдийн санхүүгийн чадамжгүй байдлаас шууд хамааралтай байна.

Харин цахим ур чадварын хувьд зорилтот таван бүлгээс ахмад настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар бусад бүлгийн иргэдтэй харьцуулахад хамгийн бага байна (Зураг 1). Бусад бүлгийн хувьд ухаалаг утас ашиглах мэдлэг чадвар ойролцоо нэг ижил түвшинд, ерөнхийдөө сайн байсан. Оролцогчдын цахим ур чадварын ялгаатай байдлыг хүн ам зүйн шинжээр нь харьцуулан үзвэл оролцогчийн хүйс болон тухайн төхөөрөмжийн хүртээмж (ашиглах боломжтой байдал) болон тухайн төхөөрөмжийг ашигласан жилийн туршлагаас хамаарсан ялгаа ажиглагдсан. Тодруулбал, эрэгтэйчүүдийн ухаалаг утас ашиглах мэдлэг, чадвар эмэгтэйчүүдийнхээс илүү байна. Мөн төхөөрөмжийг ашиглаж буй жил болон төхөөрөмжийн хүртээмжээс хамааран иргэдийн цахим ур чадвар ялгаатай байна.

⁵ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, “e-Mongolia” 3 сая дахь үйлчилгээг цахимаар амжилттай үзүүлээ – Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (cita.gov.mn), (2021 оны 7 сарын 24-нд нэвтэрсэн)

⁶ JRC Publications Repository - DIGCOMP: A Framework for Developing and Understanding Digital Competence in Europe. (europa.eu)

Зураг 1. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ДижКомп аргачлалын хүрээгээр



Үнэлгээнд авч үзсэн 5 ур чадвараас цахим контент бүтээх буюу утсаараа зураг авах, бичлэг хийх, түүнийг өөрчлөн контент бүтээх чадвар нь нийт оролцогчдын дунд хамгийн өндөр байна. Бусад 4 чадварын хувьд тус бүрд 4 оноо авахаас бүгд 3-аас бага оноо авсан байгаа нь жигд хангалтгүй байгааг илтгэж байв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ур чадвар тус бүрээр, 1-4 хүртэлх онооноос

Зорилтот бүлгийн төрөл	Мэдээлэл хайх, олж авах ур чадварын дундаж үнэлгээ	Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадварын дундаж үнэлгээ	Цахим контент бүтээх ур чадварын дундаж үнэлгээ	Аюулгүй байдлаа хангах ур чадварын үнэлгээ	Асуудлыг шийдвэрлэх ур чадварын дундаж үнэлгээ
Ерөнхий дундаж үнэлгээ	2.2	2.9	3.0	2.3	3.1
Хөгжлийн бэрхшээлтэй	2.1	2.7	2.6	2.2	2.8
Өндөр настан	1.8	2.1	2.5	1.6	2.7
Амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрх	2.6	3.4	3.5	2.9	3.2
Шилжигч өрх	2.4	3.0	3.2	2.5	3.4
Хөдөөгийн/ алслагдмал өрх	2.3	3.1	3.3	2.4	3.4

**Ур чадварын үнэлгээ 1-рүү дөхөх тусам тухайн ур чадвар муу, 4-рүү дөхөх тусам ур сайн гэж үзнэ.*

Оролцогчдын цахим ур чадварын ялгаатай байдлыг хүн ам зүйн шинжээр нь харьцуулан үзвэл оролцогчийн хүйс болон тухайн төхөөрөмжийн хүртээмж (ашиглах боломжтой байдал) болон тухайн төхөөрөмжийг ашигласан жилийн туршлагаас хамаарсан ялгаа ажиглагдсан. Тодруулбал, залуу оролцогчдын цахим орчинг сонирхох байдал, ур чадвар нь ахимаг насны оролцогчдоос илүү сайн байна. Өөр нэг ажиглагдсан зүйл нь эрэгтэйчүүд нийтдээ цахим хөгжил, үйлчилгээг дэмжсэн, эерэг хандлагатай байгаа боловч ухаалаг утас ашиглах бодит чадвар, сошиал орчингийн идэвх зэрэг нь эмэгтэйчүүдийнхээс доогуур байна. Эмэгтэйчүүд цахим үйлчилгээ болон сошиал орчинг идэвхтэй ашигладаг учраас төрөл бүрийн эерэг болон сөрөг туршлагуудыг хуримтлуулж байна. Жишээлбэл, тэд цахим халдлага, дайралт болон үнэн мэдээллээс ялгагдахгүй хуурамч мэдээлэлтэй таарах тохолдол элбэг байдаг. Үүнийхээ улмаас цахим орчингоос болгоомжлох хандлага ажиглагдлаа. Мөн төхөөрөмжийг ашиглаж буй жил болон төхөөрөмжийн хүртээмжээс хамааран иргэдийн цахим ур чадвар ялгаатай байна.

Бүлэг	Бүлгийн онцлог, ялгаатай үр дүн
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд	<ul style="list-style-type: none"> ХБИ нь орлогоос шалтгаалсан цахим хуваагдалд өртөх магадлал хамгийн өндөр байна. Тэд орчин үеийн тоног төхөөрөмж, гар утас, интернэтийн үйлчилгээ авч чадахгүй байгаагаас цахим ур чадвараа нэмэгдүүлэх нөхцөл бүрдэхгүй байна. Нөгөө талаас, боловсролын түвшин доогуур, цахим төхөөрөмжүүд дээр ажиллаж чадахгүйгээс болж ХБИ-ийн ажил хийж, орлого олох боломжийг хязгаарлаж байна. ХБИ дээрх учир шалтгаан, үр дагаврын гинжин тойрогт орсон байна. Төрийн болон хувийн хэвшлийн санал болгож буй цахим бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд ХБИ-ийн хэрэгцээг харгалзаагүй байна. Тиймээс ХБИ цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээг бие даан авч чаддаггүй, үргэлж бусдаас тусламж, дэмжлэг авч хамааралтай байх нөхцөл бүрдсэн байна. Жишээлбэл, цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний зааварчилгаа зургаар өгөгдөх нь түгээмэл байдаг гэвч энэ нь хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэдийн хэрэглэдэг дуу авианы төхөөрөмж уншихгүй байх нөхцлийг үүсгэдэг. Харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд Монгол Улсад өргөн хэрэглэгддэг “веб сайт”-ууд, “аппликейшн”-ууд, тэдгээрийг дэмжин ажилладаг төхөөрөмжүүд тэдний тусгай хэрэгцээнд нийцдэггүй байх нь тэднийг цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ авах, нийгмийн амьдралд оролцоход саад учруулж байна. Түүнчлэн сонсголын бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй асуудал нь бичиг үсэг тайлагдаагүй, унших, бичих чадвар дутмаг явдал бөгөөд энэ нь цахим ур чадвараа байнга хөгжүүлэхэд томоохон бэрхшээлийг үүсгэж байна.
Алслагдмал бүсэд амьдардыг иргэдийн хувьд	<ul style="list-style-type: none"> Судалгаанд хамрагдсан хотын захын алслагдсан хороололд амьдардаг иргэд, хөдөөгийн малчин өрхүүдийн хувьд нийтлэг тулгарч буй бэрхшээл нь интернэтийн хурд, сүлжээний асуудал байна. Алслагдсан бүсэд оршин суудаг өрхүүдийн хувьд амьжиргааны түвшин харьцангуй бага ба ухаалаг гар утас, төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй байна. Үүнээс шалтгаалан алслагдсан хэсэгт оршин суудаг хүүхдүүд хичээл хийх боломж нөхцөл муу, боловсролын үйлчилгээнээс хохрох магадлал өндөр байна. Малчин өрхийн хувьд интернэтийг ашиглан голдуу мал, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ ханш, малын эм тарианы үнэ, вакцины талаарх мэдээлэл зэргийг голчлон авдаг байна. Мөн хувийн харилцаа холбоо, хүүхдүүдийн хичээл, сургууль, боловсролын зорилгоор нийтлэг ашиглаж байна. Интернэт, цахим орчны үр шимийг бүрэн хүртэх, амьдрал ахуйдаа ашиглахад гадаад хэлний бэрхшээл нийтлэг тулгардаг байна.
Шилжин суурьшигч өрх	<ul style="list-style-type: none"> Шилжин суурьшигч өрхийн хувьд интернэт, цахим орчныг утастай болон утасгүй интернэт дата авч ашигладаг. Энэ бүлгийн иргэдийн гар утас компьютер ашиглах чадвар харилцан адилгүй ба дийлэнхдээ гэр бүлийн гишүүдээсээ дэмжлэг авч байна. Ялангуяа нас ахих тусам гар утас, төхөөрөмж ашиглах чадвар сул байх хандлага ажиглагдаж байна. Бусад бүлгийн адил цахим орчинд мэдээлэл хайх, аюулгүй байдлаа хангах ур чадвар хамгийн сул байна. Гэвч энэ бүлгийн цахим орчинд харсан мэдээлэл дахин хайж олох чадвар бусад бүлгүүдтэй харьцуулахад хамгийн сайн байна. Цахим орчинд нийгмийн болон улс төрийн асуудлаар өөрийн үзэл бодлоо идэвхтэй илэрхийлдэггүй ч таалагдсан постыг хувийн профайлдаа хуваалцах, лайк дарах зэргээр өөрсдийн байр сууриа илэрхийлдэг.
Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувьд	<ul style="list-style-type: none"> Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хувьд ам бүл олон тул өрхийн гар утас, компьютер хүрэлцээгүй байна. Энэ бүлгийн иргэдийн ажил эрхлэлт бага учир өдөр тутамдаа интернэт орчинд маш их цагийг өнгөрөөдөг. Гэвч ашигладаг цахим суваг нь Фэйсбүүкээр хязгаарлагдаж байна. Энэ бүлгийн иргэд цахим ур чадварын 5 үзүүлэлтээрээ бусад бүлгүүдээс хамгийн өндөр үнэлгээ авсан. Өөрөөр хэлбэл цахим орчинд бусадтай харилцах, асуудлыг шийдвэрлэх, цахим контент бүтээх хангалттай сайн байна. Харин мэдээлэл хайж олох, цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар бусад 3-н үзүүлэлттэй харьцуулахад бага ч судалгаанд хамрагдсан зорилтот бүлгүүд дундаа хамгийн сайн байна. Мэдээлэл хайж олох, цахим орчинд бусадтай харилцах чадвараа нэмэгдүүлэхэд энэ бүлгийн иргэдийн Англи хэлний мэдлэг дутмаг байгаа нь нөлөөлж байна.
Ахмад настай иргэдийн хувьд	<ul style="list-style-type: none"> Ахмад настай иргэдийн хувьд бусад бүлгүүдтэй харьцуулахад төхөөрөмж, интернэтийн хүрэлцээ сайн боловч цахим ур чадвар хамгийн сул байна. Тиймээс бүтээгдэхүүн, үйлчилгээг биечлэн авах сонирхол өндөр байна. Цахимаар мэдээлэл авдаг суваг нь Фэйсбүүкээр хязгаарлагдаж байна. Банк, и-баримт, и-монгол зэрэг аппликейшнуудыг ажиллуулахад үйлдлүүдийг нь ойлгоход төвөгтэй байдаг гэсэн шалтгааны улмаас эдгээр аппликейшныг хэрэглэхгүй байна. Ахмад настай иргэд гар утсаараа зураг авах, бичлэг авах, утасныхаа гэрэл, дууг нэмж хасах зэрэг энгийн үйлдлийг хийж чадаж байгаа ч цаашид илүү олон үйлдэл, тохиргоо хийж сурах, цахим ур чадвараа сайжруулах сонирхол бага байна. Учир нь өөрсдийн амьдралд нь хэрэгцээтэй биш гэж үзэж байна. Цахим орчны мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээллийн нууцлалын талаарх мэдээлэл боломжит хэмжээнд мэдэж байгаа ч хэрэгжүүлэх, хэрхэн урьдчилан сэргийлэх тал дээр мэдлэг, ойлголтой байна. Төхөөрөмж болон цахим орчны мэдээллийн аюулгүй байдлыг хангах чадвар сул байна.

Нийт бүлгүүдийн хувьд ахисан түвшний үйлдэл хийх, илүү өргөн хүрээний мэдээлэл авах, аюулгүй байдлаа цахим орчинд хамгаалах, гар утас, интернэтийг ашиглах явцад өөрт тулгарсан бэрхшээлүүдээ шийдвэрлэхэд одоогийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх шаардлага байна. Үүнд:

- Мэдээллийг олон эх сурвалжаас авдаг болохын тулд Англи хэлний мэдлэгээ нэмэгдүүлэх, мэдээллийн найдвартай байдлыг шалгах аргуудад суралцах,
- Бусадтай харилцах, хамтран ажиллах чадвараа нэмэгдүүлэхийн тулд өргөн хэрэглэгддэг цахим аппликейшнуудыг ажиллуулах чадвараа нэмэгдүүлэх, и-мэйл хаяг нээх, ашиглах чадварт суралцах. Түгээмэл ашиглагддаг аппликейшнуудад Тиймс, Зүүм, Фэйсбүүк messenger багтана.
- Цахим контент бүтээх чадвараа нэмэгдүүлэхийн тулд зураг, бичлэг зэргийг эвлүүлэх, маркетинг ашиглах, клип хийж сурах зэрэг чадваруудыг эзэмших
- Бусдаас хамааралгүйгээр гар утас, төхөөрөмжөө ашиглаж мэдээлэл авах, бусадтай харилцах, түгээмэл ашиглагддаг аппликейшн гар утасныхаа аюулгүй байдлыг хангах чадварыг нэмэгдүүлэх.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Түвшин	Санал, зөвлөмж	Хариуцах эзэн
Бодлого боловсруулах, батлах түвшинд	Хотын захын хороолол, хөдөөгийн өрхүүдэд чиглэсэн интернэт, сүлжээний дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж өгөх	УИХ, холбогдох яамд, ХХМТГ
Хэрэгжүүлэх түвшинд	Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай төсөв, санхүүжилтийг батлах	ХХМТГ
	2022 онд “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлэх, сургамж туршлага бүхий асуудлуудыг тодруулах замаар хугацаа алдалгүй дараагийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	ХХМТГ, ХЭГ, иргэний нийгмийн байгууллагууд
	•Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаанд ашигласан арга зүй, сургамжийг ашиглан иргэдийн цахим ур чадварыг үнэлэх үндэсний судалгааг зохион байгуулах	ХХМТГ, ҮСГ
	Сонсгол, харааны бэрхшээлтэй иргэдэд цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ авах нөхцөлийн бүрдүүлэх. Үүнд WCAG олон улсын стандартыг албан ёсоор Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2019 онд орчуулж гаргасан “Веб контентийн хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал” ()-ыг ашиглах боломжтой. Энэ аргачлалын дагуу И-монголиа болон бусад төрийн, хувийн хэвшлийн үйлчилгээний сайтуудад үнэлгээ хийх, ХБИ болон бусад зорилтот бүлгийн иргэдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн сайт, аппликейшны хүртээмжийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах	ХХМТГ, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил
	Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгуулах . Агуулга нь тухайн бүлгээс хамаарч өөр байж болно. Жишээлбэл, ахмад настны бүлэгт хамгийн түгээмэл ашиглагддаг цахим хуудас, аппликейшныг ажиллуулах, гар утасны тохиргоог өөрчлөх гэх мэт тэдний сонирхолд нийцсэн сургалтын агуулгыг зааж болох юм	ХХМТГ, ХНХЯ-ны харьяа байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллага
	Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхдээ цахим төхөөрөмжгүй иргэдийн хэрэгцээг харгалзан үзэж уламжлалт хэлбэрээр авах хувилбарыг санал болгох . Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломжтой ажлын байрны зарыг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох, цахим хичээлийг алслагдсан бүс, хөдөө амьдарч буй хүүхдүүдийн хэрэгцээг харгалзан үзэж, хэвлэмэл хувилбараар санал болгох гэх мэт.	ХНХЯ, БШУЯ, ажил олгогчид
	Иргэдэд цахим ур чадварын тухай нэгдсэн, ерөнхий ойлголтыг өгөх, ач холбогдлыг ойлгуулах. Жишээлбэл, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим мэдээллийн найдвартай байдлыг шалгах, цахим контент бүтээж сурах, ажил хөдөлмөр олох боломжоо нэмэгдүүлэх гэх мэт	ХНХЯ-ны харьяа байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд
	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд оролцуулахын ач холбогдлыг сурталчилж, тэдний гэр бүл, ойр дотны хүмүүсийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх	ХНХЯ-ны харьяа байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд



СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

IRIM судалгааны хүрээлэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэргэдэх Хурдасгуур Лаборатори нэгжийн захиалгаар “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”-г 2021 оны 5 дугаар сарын 26-аас 8 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэв.

1.1. Судалгааны зорилго

Судалгааны гол зорилго нь зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварын талаар сайн судлагдаагүй зүйлүүдийг олж мэдэх буюу сонгосон бүлгүүдэд ямар асуудал бэрхшээл тулгардаг, мөн дээрх бүлгүүдийн хандлага, үнэт зүйл хэрэгцээ зэрэг урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлүүдийг олж нээх явдал юм. Энэхүү зорилгодоо үндэслэн судалгааны арга зүй, аргачлалаа сонгосон. Судалгааны хүрээнд тодорхой үзэгдлийн талаар шинийг судалж илрүүлэх шаардлага үүсч буй тул хамгийн тохиромжтой чанарын, индуктив арга зүй сонгосон ба энэ нь судалж буй асуудлын учир шалтгааныг илрүүлэхэд ач холбогдолтой байдаг.

1.2. Арга зүйн хүрээ

Энэхүү судалгаанд Европын Холбооны ДижКомп 1.0⁷ “Иргэдийн цахим чадавхыг үнэлэх хүрээ”-г сонгон, судалгааны дизайн, хэрэглэгдэхүүнээ боловсруулахдаа ашигласан. Судалгааны хагас бүтэцчилэгдсэн асуулга болон фокус бүлгийн ярилцлагын удирдамж дараах ерөнхий болон дэд хэсгүүдээс бүрдсэн.

Хүснэгт 2. Цахим ур чадварын хүрээ, хэрэглэгдэхүүний бүрэлдэхүүн хэсгүүд

Түүврийн хүрээ ба стратеги	Дэд бүрэлдэхүүн хэсэг
1. Мэдээлэл хайх, олж авах ур чадвар	<ul style="list-style-type: none"> Интернэтээс хайлтын тусламжтайгаар мэдээлэл олох Үнэн зөв эсэхийг үнэлэн дүгнэх Цуглуулсан мэдээлэл болон файлаа хадгалж, зохион байгуулах
2. Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	<ul style="list-style-type: none"> Цахим платформ, технологийн тусламжтайгаар хүмүүстэй харилцах Хамтран ажиллах Мэдлэг, мэдээлэл хуваалцах Цахим орчинд ёс зүй баримтлах Өөрийн гэсэн цахим профайл мэдээлэл бүхий дүр төрхтэй болох
3. Цахим контент бүтээх ур чадвар	<ul style="list-style-type: none"> Дуу, дүрс, текст зэрэг олон төрлийн контент бүтээх Цахим контентод өөрчлөлт оруулах Цахим орчинд оюуны өмчийг дээдлэх
4. Аюулгүй байдлаа хангах ур чадвар	<ul style="list-style-type: none"> Ашиглаж байгаа төхөөрөмжөө хамгаалах Хувийн мэдээллээ хамгаалах Цахим технологи ашиглахтай холбоотойгоор эрүүл мэндээ хамгаалах Байгаль орчноо хамгаалах
5. Асуудлыг шийдвэрлэх ур чадвар	<ul style="list-style-type: none"> Өөрт тулгарсан техникийн асуудлыг шийдвэрлэх Хэрэгцээндээ тохирсон технологийн шийдлийг олох Цахим ур чадварын хэрэгцээ буюу цаашид энэ чиглэлээр сурах зүйлээ мэддэг байх

1.3 Судалгааны хязгаарлагдмал талууд, ижил төстэй судалгааны ажил гүйцэтгэхэд өгөх зөвлөмж

Нийгэм, цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэд, олон нийт, тэр дундаа зорилтот бүлгийн иргэдийн цахим орчинд ажиллах мэдлэг, ур чадварыг үнэлсэн энэхүү туршлага нь шинэ тутам байсны хэрээр судалгааны баг багагүй сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байлаа. Иймд уг ажлыг гүйцэтгэсэн судалгааны багийн туршлагад тулгуурлан цаашид үүнтэй ижил төстэй, иргэдийн цахим ур чадварыг үнэлэх судалгааны ажил гүйцэтгэхэд анхаарах асуудлуудыг мөн дор нэгтгэн орууллаа.

- **Судалгааны аргачлалын хувьд:** Тоон судалгаа нь бүлгүүдийн ялгаатай, онцлог хэрэгцээ, асуудалтай холбоотой онцлог суурь шалтгааныг гүнзгий гаргаж ирэхэд хязгаарлагдмал тул чанарын судалгааг хослуулан мэдээлэл цуглуулах нь тохиромжтой байна.
- **Хэрэглэгдэхүүний хувьд:** Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар нь харьцангуй бага тул олон улсад нийтлэг ашиглагддаг асуулга, хэрэглэгдэхүүнүүд ажиллахгүй байх сул талтай. Тиймээс олон

⁷ JRC Publications Repository - DIGCOMP: A Framework for Developing and Understanding Digital Competence in Europe. (europa.eu)

улсад ашиглагддаг хүрээнд тулгуурлан, Монголын нөхцөлд тохируулан шинээр хэрэглэгдэхүүнүүдээ боловсруулах шаардлагатай. Түүнчлэн зорилтот бүлгийн иргэдийн цахим, техник, технологитой холбоотой нэр томъёог ойлгох мэдлэг дутмаг тул аль болох иргэдийн өдөр тутмын амьдралд ойр, зарим тохиолдолд ярианы нэр томъёог сонгож, жишээгээр тодруулж өгч хэрэглэгдэхүүндээ тусгах хэрэгтэй.

- **Түүврийн хувьд:** Энэ судалгааны хүрээг Улаанбаатар хот болон ойролцоо газар нутгийг хамарсан байгаа нь цахим дэд бүтэц, үйлчилгээний төвлөрлийг харгалзаж үзсэнтэй холбоотой юм. Үүний улмаас үндэстний цөөнх, алслагдмал нутгийн малчид зэрэг хүн амын бүлгүүдэд хүрч очих боломжгүй болсон. Хороодын зааварлагч нартай хамтарч ажилласны үр дүнд цөөн боловч малчин өрхүүдийг судалгаанд хамруулж чадсан. Мөн зорилтот бүлгүүдийн төлөөлөл болох холбоод, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудтай ярилцсанаар тодорхой бүлгийн асуудлаар илүү гүнзгийрүүлсэн мэдээлэл олж авах боломжтой байв.
- **Мэдээлэл цуглуулалтын хувьд:** Цахим ур чадвар, техник технологийн талаар хүмүүсийн ойлголт ялгаатай учир өөрсдийн чадварыг үнэлүүлсний дараа даалгавар гүйцэтгүүлж баталгаажуулах нь тохиромжтой байсан. Мөн фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулахдаа олон бүлгийн иргэдийн холихгүйгээр зөвхөн нэг бүлгийн иргэдийн дунд хийх нь илүү үр дүнтэй байна. Гэсэн хэдий ч, дараагийн удаа ижил төстэй судалгаа хийгдэх юм бол бүлэг хоорондын харилцаа хамаарлыг судлаж үзэх нь чухал байж болзошгүй.

1.4. Түүврийн хүрээ ба стратеги

Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгааг Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул, Налайх дүүрэгт зохион байгуулав. Судалгаанд (1) хөгжлийн бэрхшээлтэй иргэн, (2) өндөр настай иргэн, (3) амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрхийн төлөөлөл, (4) шилжигч өрхийн төлөөлөл, (5) хөдөөгийн алслагдмал өрхийн төлөөллийг хамруулсан 78 хүнтэй хагас бүтэцчилэгдсэн ярилцлага хийв. Түүнчлэн Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо, Түгээмэл хөгжил ТББ-ын төлөөллүүдтэй гүнзгийрүүлсэн ярилцлага зохион байгуулсан. Зорилтот бүлгийн иргэдийг тодорхойлсон шалгуур үзүүлэлттэй Хавсралт-1-ээс танилцах боломжтой.

Хүснэгт 3. Хүн ам зүйн мэдээлэл /зорилтот бүлгээр/

		Зорилтот бүлгийн төрөл				
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх	Өндөр настан	Амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрх	Шилжигч өрх	Хөдөөгийн/алслагдмал өрх
Нийт судалгаанд хамрагдсан		16	16	16	14	16
Дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	31.3%	37.5%	50.0%	21.4%	31.3%
	Баянзүрх дүүрэг	43.8%	18.8%	31.3%	28.6%	18.8%
	Хан-Уул дүүрэг	25.0%	43.8%	18.8%	50.0%	43.8%
	Налайх	0.0%	0.0%	0.0%	0.0%	6.3%
Хүйс	Эрэгтэй	50.0%	50.0%	37.5%	42.9%	31.3%
	Эмэгтэй	50.0%	50.0%	62.5%	57.1%	68.8%
Нас	25 хүртэл настай	0.0%	0.0%	31.3%	14.3%	18.8%
	26-35 настай	18.8%	0.0%	37.5%	35.7%	6.2%
	36-45 настай	56.2%	0.0%	25.0%	21.4%	50.0%
	46-55 настай	25.0%	6.3%	6.2%	14.3%	18.8%
	56-аас дээш настай	0.0%	93.8%	0.0%	14.3%	6.2%
Боловсролын түвшин	Боловсролгүй	6.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%
	Бага (1-5)	12.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%
	Суурь (6-9)	6.3%	18.8%	0.0%	14.3%	12.5%
	Бүрэн дунд (10-12)	50.0%	37.4%	75.0%	64.3%	56.3%
	Техник мэргэжлийн дээд	12.5%	25.0%	12.5%	0.0%	12.4%
	Дээд	12.5%	18.8%	12.5%	21.4%	18.8%

Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн дундаж орлого 1,011,526 төгрөг ба улсын дундаж орлого 1,508,837 төгрөгөөс⁸ 33%-аар бага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхүүдийн дундаж орлого 738,000 төгрөг байгаа нь зорилтот бүлэг дотроо хамгийн бага байна.

⁸ Үндэсний статистикийн хороо ядуурал, өрхийн орлого зарлага 2020 он. https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L19&type=tables

Зураг 2. Өрхийн сарын дундаж орлого /зорилтот бүлгээр/



Өрхийн сарын харилцаа холбоондоо зарцуулдаг дундаж зардал 47,467 төгрөг мөн интернэтийн хэрэглээнд зарцуулдаг дундаж зардал 28,380 мянган төгрөг байна. Энэ нь өрхүүдийн дундаж орлого (1,011,526 төгрөг), судалгаанд хамрагдсан өрхийн дундаж ам бүлийн тоо 4 байгаатай харьцуулахад харьцангуй өндөр зардал юм.

Зураг 3. Сарын харилцаа холбоо болон интернэтэд зарцуулдаг дундаж зардал /зорилтот бүлгээр/



2

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР





2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР

2019 оны байдлаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 107.1 мянган иргэн байна. Тэд бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогоос⁹ болоод интернэт, цахим орчинд ажиллаж, амьдрах боломж хязгаарлагдмал, цаашлаад нийгэм, эдийн засаг, хувь хүний хөгжлийн түвшингээрээ бусад бүлгийн хүмүүсээс хоцрох хандлагатай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (ХБИ) дотор харааны бэрхшээлтэй иргэн (10.9%), сонсголын бэрхшээлтэй иргэн (8%), хөдөлгөөний буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэн (20.1%)-ийг эзэлж байна¹⁰.

Бид судалгаандаа хараа¹¹, сонсгол¹², тулгуур эрхтний бэрхшээл¹³-тэй иргэдийн төлөөлөлтэй ярилцлага хийж тэдний цахим хүртээмж, мэдлэг, ур чадварыг тодруулахыг зорилоо. Судалгаанд хамрагдсан ХБИ-ийн нийтлэг дүр төрхийг Баярмаагаар төлөөлүүлэв.

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүйн үзүүлэлт

	Нэр: Баярмаа	Сарын орлого: 738'000₮ - улсын дунджаас 52% бага
	Нас: 41	Сард интернэтэд гаргадаг зардал: 32'000₮
	Ам бүл: 3	Сард харилцаа холбоонд гаргадаг зардал: 44'563₮
	Хөдөлмөр эрхлэлт: Ажилгүй, группд	
Зонхилон хэрэглэдэг аппликэйшн:		

2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим хүртээмжийн байдал

ХБИ цахим хуваагдалд хамгийн их өртөж буй бүлэг болох нь харагдаж байна. Энэ байдал нь ХБИ цахим орчноос мэдээлэл авах, цахим орчинд хүмүүстэй харилцах, цаашлаад цахим орчны давуу талуудыг ашиглах боломжийг хязгаарлаж байна.

Баярмаа сонсголын бэрхшээлтэй. Баярмаагийн гэр бүл өндөр хурдны интернэтэд холбогдоогүй. Интернэтийг шаардлагатай үедээ дата авах байдлаар ашиглаж байна. Сард харилцаа холбоондоо 44,563 төгрөг, интернэтэд 32,000 төгрөг зарцуулдаг ба энэ өрхийн орлогын 10%-ийг эзэлж байна.



Шигтгээ 1.

... Юнившин, гэр интернэт бол хурдан, хэрэгцээнд хүрэлцээтэй байдаг. Харин дата гацдаг, ашиглах хугацаа нь богинохон ч үнэ өртөгийн хувьд боломжийн. Гэхдээ олон дахин авах юм бол ч үнэтэй л болдог юм шиг санагддаг.

ХБИ-ийн дунд хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

⁹ Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулан ойлгоно" гэж заасан байдаг.

¹⁰ 2019 оны байдлаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 107.1 мянган иргэн байна. Тэд бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогоос болоод интернэт, цахим орчинд ажиллаж, амьдрах боломж хязгаарлагдмал, цаашлаад нийгэм, эдийн засаг, хувь хүний хөгжлийн түвшингээрээ бусад бүлгийн хүмүүсээс хоцрох хандлагатай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (ХБИ) дотор харааны бэрхшээлтэй иргэн (10.9%), сонсголын бэрхшээлтэй иргэн (8%), хөдөлгөөний буюу тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэн (20.1%)-ийг эзэлж байна.

Бид судалгаандаа хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээл -тэй иргэдийн төлөөлөлтэй ярилцлага хийж тэдний цахим хүртээмж, мэдлэг, ур чадварыг тодруулахыг зорилоо. Судалгаанд хамрагдсан ХБИ-ийн нийтлэг дүр төрхийг Баярмаагаар төлөөлүүлэв.

¹¹ Харааны бэрхшээлтэй-харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "харах" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;

¹² Сонсголын бэрхшээлтэй- сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "сонсох" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг

¹³ Хөдөлгөөний бэрхшээлтэй- биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг;

Датагаа хэмнэх үүднээс Баярмаа 7 хоногт 1-3 удаа л интернэт ашигладаг ба нэг орохдоо ойролцоогоор 30-60 минутыг зарцуулдаг байна. Ингэхдээ Фэйсбүүкээ шалгаж, найз нөхөд хамаатан садантайгаа харилцах, и-баримт дээр баримтуудаа шивэх, банкны дансны үлдэгдлээ шалгадаг.

Баярмаа урьд нь товчлууртай утас хэрэглэдэг байсан бөгөөд саяхан гэр бүлийн хүнтэйгээ дундаа нэг ухаалаг гар утас авсан. Дундаа хэрэглэдэг ч гэсэн, нэг гар утастай байхыг боломжийн, хэрэглээнд таарч байна гэж үзэж байна. Хэдийгээр хүүхдийн хичээл хийлгэхэд компьютер хэрэгтэй байгаа ч, санхүүгийн боломжгүй учраас компьютер авч чадахгүй байгаа.

КОВИД-19 цар тахлын үед бүх зүйл интернэтээр хийгдэх хэрэгтэй болж байгааг төдийлөн таашаадаггүй. Учир нь онлайн үйлчилгээг авахад цахим хуудас, аппликейшн түүний бэрхшээл, тусгай хэрэгцээг харгалзаагүй, хэрэглэхэд хэцүү, ойлгомжгүй байдаг байна. Төрийн болон бусад үйлчилгээг авахдаа заавал хэн нэгний туслалцааг авч, дагуулж явдаг ба эдгээрийг хүний туслалцаагүйгээр хийх сонирхолтой байдаг. Хөл хорионы үед онлайн үйлчилгээг зайлшгүй шаардлагатай тохиолдолд л авч байсан талаараа ярьсан юм.

66

Шигтгээ 2.

*...Миний хувьд Худалдаа хөгжлийн банкаар цалингаа авдаг. **АТМ ашиглаж огт чаддаггүй.** Интернэт банкны үйлчилгээг нээлгэсэн ч би өөрөө хүний тусламжгүйгээр ашиглаж чаддаггүй. Зарим товчлуурууд дээр хэд хэд очих хэрэгтэй болдог, дансны дугаар оруулахад олон оронтой тоо оруулахад дахин шалгах боломжгүй гэх мэтчилэн олон асуудал үүсдэг.*

Харааны бэрхшээлтэй иргэнтэй хийсэн ярилцлагаас

66

Шигтгээ 3.

*... Сонсголгүй иргэний нийгмийн харилцаанд орох гол хэрэгсэл бол дохионы хэл, дохионы хэлээр дамжуулан мэдээ мэдээллийг солилцоно. Төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний ажилчид дохионы хэлний мэдлэггүй учир харилцахдаа заавал хүнтэй очих шаардлага тулгардаг. **Бид бүхэн нүдээрээ хараад гараараа дохиогоор ярилцдаг учир ерөөсөө тод дүртэй ойлгомжтой зүйл хэрэгтэй байдаг.***

Сонсголын бэрхшээлтэй иргэнтэй хийсэн ярилцлагаас

66

Шигтгээ 4.


*... Бидний хувьд мэдээллийг сонсоод авчихдаг эргээд түүнийгээ бас хэлж ярьж чаддаг учир сонсголгүй иргэдийн хажууд мэдээллийг харьцангуй сайн авдаг гэсэн үг. **Гэхдээ мэдээ, мэдээлэл авдаг төрийн сайтууд, том үйлчилгээний байгууллагуудын сайтууд, мөн их дээд сургуулиудын сайтууд харааны бэрхшээлтэй хүмүүст маш хүртээмжтэй байх хэрэгтэй байна.***

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хийсэн ярилцлагаас

2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар

Баярмаагийн цахим ур чадварыг 5 үзүүлэлт дээр харвал нийт 4¹⁴ оноос авахаас бүх үзүүлэлт дээр хангалтгүй буюу 3 хүрэхгүй оноо авсан байна. Үзүүлэлтээр нь нарийвчилж харвал цахим орчноос мэдээлэл авах ур чадвар (2.1) болон цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар (2.2) хамгийн сул байна. Үүнд нас болон хүйсээс хамаарсан мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй.

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварын нэгдсэн үр дүн




2.3.1 Мэдээлэл хайх, олж авах ур чадвар

Судалгааны үр дүнгээс харахад Баярмаа өөрийгөө бие даан мэдээлэл хайх, олж авах энгийн чадвартай гэж үзэж байгаа ч, мэдээлэл авдаг суваг нь дохионы хэлээр нэвтрүүлдэг телевизийн цөөн суваг, Фэйсбүүкээр хязгаарлагдаж байна. Сонсголын бэрхшээлтэй иргэд хоорондоо Фэйсбүүк мессенжерээр видео дуудлага хийж харилцдаг, олж авсан мэдээллийг хоорондоо дамжуулдаг ажээ. Ажиглалтаас харахад мэдээллийг Фэйсбүүк дотроос хайж байгаа бөгөөд үүнийгээ интернэтээс хайж байна гэж ойлгодог. Хайлтаа нарийсгах, түлхүүр үг ашиглах гэх мэт өөртөө тохирсон хайлтын аргуудыг мэдэхгүй байна. Ерөнхийдөө, Баярмаагийн унших бичих чадвар тийм ч сайн биш тул, янз бүрийн хайлт хийх сонирхолгүй. Гарч ирсэн мэдээллийг эрэмбэлэх, хадгалах, буцааж олох ур чадвар хангалтгүй байна. Одоогоор хийж чаддаг зүйл нь таалагдсан мэдээллээ өөрийн Фэйсбүүк профайл дээр хадгалах аргыг л мэдэж байна. Тэрээр ямар мэдээлэл хэрэгтэй байгаагаа илэрхийлж, ойлгуулж чадахгүй байна.

Нийт ХБИ-ийн хувьд цахим орчинд мэдээллийн найдвартай байдлыг шалгах зуршил, чадвар дутмаг байна. Мэдээллийг үнэн худал эсэхийг ялгаж салгадаггүй, ихэнхдээ ам дамжсан яриаг мэдээллийн эх сурвалж болгодог нь ажиглагдаж байв.

Зураг 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хайж олох ур чадвар




14 Ур чадварын үнэлгээ 1-рүү дөхөх тусам тухайн ур чадвар муу, 1-тэй тэнцүү бол тухайн ур чадвар огт хангагдаагүй, 4-рүү дөхөх тусам ур чадварын үнэлгээ сайн, 4-тэй тэнцүү бол тухайн ур чадвар бүрэн хангагдсан гэж үзнэ. Тухайн ур чадварыг бүрэн чаддаг бол 4, огт чаддаггүй эсвэл мэдэхгүй бол 1 гэдэг үнэлгээ өгнө, тэдгээрийн дундаж үнэлгээгээр ур чадвар бүрийн эцсийн үнэлгээг гаргав.

2.3.2 Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар

Сонголын бэрхшээлтэй хүмүүсээс ялгаатай нь, хараагүй болон харааны алдагдалтай хүмүүс яриагаар өөрийн санаа бодол, байр сууриа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байдаг. Харин сул хараатай хүмүүсийн хувьд бусадтай мессеж, чат, дуудлагаар харилцаж чадах хэдий ч, дэлгэцийн нягтрал, хэмжээ зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг учир ашиглаж буй төхөөрөмжийн хүчин чухал байдаг. Сонголын бэрхшээлтэй Баярмаа шиг хүмүүсийн хувьд өөртэй нь ижил төрлийн бэрхшээлтэй, дохионы хэлээр харилцдаг Монгол төдийгүй, гадаадад иргэдтэй харилцаж байна. Энгийн хүмүүсийн дунд дохионы хэлийг ойлгож харилцах хүмүүс ховор байгаа нь сонголын бэрхшээлтэй иргэд нийгэм, улс төр, эдийн засаг зэрэг асуудлаар өөрсдийн дуу хоолойгоо олон нийтэд хүргэхэд саад болж буй гол хүчин зүйл болж байна. Бусадтай цахимаар харилцаа Фейсбүүк видео мессенжерийг түгээмэл ашигладаг ч олуулаа ярих дуудлага үүсгэх зэрэг ахисан шатны үйлдэл хийх чадвар Баярмаад дутмаг байна.

Зураг 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар




Баярмаа сошиал орчинд бусдын орон зайг хүндэтгэн, биеэ зөв авч явах ёстой талаар ерөнхийдөө мэддэг. Хэдий тийм ч цахим орчинд ялангуяа Фэйсбүүкийг хувийн болон ажил мэргэжлийн зорилгоор ялгаатай хэрэглэх талаар мэдлэг, ойлголт бага байна. Ялгаж хэрэглэх шаардлага гардаггүйгээ тогтмол харилцдаг хүмүүс нь өөртэй нь ижил төрлийн бэрхшээлтэй, дохионы хэл ойлгодог цөөн хүн байдагтай холбон тайлбарлаж байна.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд: Сонсох, харах, сэтгэн бодох чадвар нь хэвийн учир бусадтай харилцах, хамтран ажиллах чадвар харьцангуй өндөр байгаа ч, гэр бүлийн хүмүүс, ойр дотны хүмүүсийн дэмжлэг дутмаг байдгаас нийгмийн амьдрал оролцох, өөрсдийгөө хөгжүүлэх боломжоо алдах нь түгээмэл байна. Төрийн бус байгууллага байгуулж сургалт, нөлөөллийн ажил, боловсролын үйлчилгээ үзүүлж буй сайн туршлагауд байна.

2.3.3. Цахим контент бүтээх ур чадвар

Баярмаа бусдын тусламжгүйгээр зураг авч, видео хийж чадаж байгаа ч түүнийгээ эвлүүлэх, хэлбэр, хэмжээг өөрчлөх зэрэг ур чадвар дутмаг байна. Тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдээс ялгаатай нь сонсголын бэрхшээл, харааны бэрхшээлтэй иргэд энэ ур чадвараа нэмэгдүүлэх сонирхол бага байна.

Зураг 7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим контент бүтээх ур чадвар




Бүрэн хараагүй иргэдээс бусад харааны алдагдалтай иргэд зураг, бичлэг хийж, түүнийгээ бусадтай хуваалцах чадвартай байна. Харин ахисан түвшний ур чадварууд болох авсан зургаа өөрчлөх, эвлүүлж контент бүтээх чадвар сул байна. Харааны бэрхшээлтэй иргэд зураг, бичлэг авч чадаж байгаа ч түүнийгээ янзлах, цаашлаад цахим контент бүтээх сонирхол бага байна.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд зураг, видео хийх чадвараа хөгжүүлээд ажил, хөдөлмөр эрхэлж, орлогоо өсгөх сонирхол сонсгол болон харааны бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад өндөр байна. Учир нь тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдэд ном шивэх, операторын ажил зэрэг цахимд суурилсан ажлын байр олдоц ихтэй байдаг. Тиймээс компьютер дээр ажиллах чадвараа нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр байна. Хүйсээр нь харвал эрэгтэй оролцогчдын хувьд дээрх чадвар эмэгтэй оролцогчидтой харьцуулахад бага байна. Тэдгээр оролцогчид өөрсдийгөө зураг, бичлэгийг бусадтай хуваалцах чадвартай гэж үнэлж байгаа ч даалгавар гүйцэтгэж чадахгүй байсан.

2.3.4. Аюулгүй байдлаа хангах ур чадвар

ХБИ цахим орчинд өөрсдийн хувийн мэдээллийг олон нийтэд хуваалцах нь эрсдэлтэй талаар суурь ойлголт сайтай байна. Хэдий тийм ч хэрхэн хамгаалах аргаа мэдэхгүй байна. Гар утас, төхөөрөмждөө нууц үг хийх чадвар сул, сонирхол бага байна. Үүнд гар утасны тохиргоо, үйлдэл зэрэг нь Англи хэл дээр байдаг нь нөлөөлж байна. Бусад бүлэгтэй харьцуулахад тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд утас, төхөөрөмжийнхөө нууц үгийг солих чадвар сайтай байна.

Зураг 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар




Баярмаа болон түүнтэй ижил ХБИ-ийн дунд цахим орчинд зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дуу, кино, бичлэг зэргийг үзэх, хуулбарлан тараах нь хууль бус талаарх ойлголт харилцан адилгүй байна. Харин цахим орчинд өөрсдийн ажил, мэргэжил, гэр бүлийн мэдээлэл, овог нэр, утасны дугаар, банкны картын нууц үг, оршин байгаа газрын талаарх мэдээллийг хуваалцахаас зайлсхийдэг, эдгээрийг олон нийтэд дэлгэх нь аюултай гэж үзэж байна.

2.3.5. Асуудлыг шийдвэрлэх ур чадвар

ХБИ бусдын тусламжгүйгээр утас, компьютер, хамгийн их ашигладаг аппликейшнийхаа нууц үгийг солих чадвар дутмаг байна. Ихэвчлэн хүний тусламжтайгаар эдгээр үйлдлийг хийдэг ба өөрсдийн төхөөрөмж, хувийн аккаунтдаа нууцлалын хээ, цоож хийх сонирхолгүй байна.

Зураг 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар



Баярмаа утасныхаа гэрэл, дууг нэмж, хасах зэрэг энгийн үйлдлүүдийг товчлуурын тусламжтайгаар хийж байна. Харин утасныхаа тохиргоог өөрчлөхийн тулд олон алхамт үйлдлүүдийг хийж чадахгүй, утасны тохиргоо өөрчлөх хэсэг Монгол хэл дээр байгаа тохиолдолд ашиглаж чадаж байв. Хувийн хаяг руу нь гаднын этгээд орж ирсэн мэдээллийг авсан үед хэрхэн хамгаалах, ямар арга хэмжээ авах талаар мэдлэг,

ойлголтгүй байна. Баярмаа гар утас, интернэт ашиглахтай холбоотой ямар нэгэн бэрхшээл тулгарахад ихэвчлэн гэр бүлийнхнээсээ дэмжлэг авдаг бол ховор тохиолдолд зааварчилгааг нь унших, найз нөхөд, утасны операторын компаниудтай холбогдож асуудаг байна.

2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ

Баярмаа болон түүний ах цахим ур чадвараа нэмэгдүүлэхэд ямар хэрэгцээ шаардлага байгаагаа төдийлөн хэлж мэдэхгүй байсан. Тиймээс фокус бүлгийн ярилцлага хийж, судалгаанд хамрагдсан ХБИ-ээс интернэт, компьютер, гар утас ашиглаад хийж сурахыг хүсэж буй зүйлсийг эрэмбэлүүлсэн. ХБИ-д (1) төхөөрөмжтэй харьцах, ажиллуулах ур чадвар, (2) бусадтай харилцах чадвар, (3) төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээг авах чадварууд хамгийн их хэрэгцээтэй байна.

Хүснэгт 4. ХБИ-ийн интернэт, компьютер, гар утастай холбоотой чадварын хэрэгцээ

	Ур чадвар	Эрэмбэ (чухлын зэргээр)
	Утасны тохиргоог бүрэн ажиллуулж сурах	I
	Харилцах (видео дуудлага, олон хүнтэй зэрэг харж дуудлага хийх г.м)	II
	Санхүүгийн үйлчилгээ авах (мобайл банк хэрэглэх)	III
	Аюулгүй байдлаа хамгаалж сурах (залилангаас хамгаалах г.м.)	III
	Программууд дээр ажиллаж сурах (зураг янзлах, шивэх, бичлэг хийж янзлах, Word, Excel г.м)	IV
	Өөрт тулгарсан жижиг гэмтэл, гацалтыг шийдэж чаддаг болох	IV
	Апп суулгах, компьютерын программ суулгах	V
	Төрийн үйлчилгээ авах (и-баримт, и-Монголиа)	V
	Онлайн дэлгүүр үйлчлүүлэх	V
	Хэрэгтэй мэдээллээ хайх, олж авах	V

ХБИ-ийн хувьд дээр дурдсан цахим ур чадварын хэрэгцээндээ зориулсан сургалтыг танхимаар авах сонирхол илүү байсан. Сургалт явуулах боломжит газруудад хорооны байр болон сургуулийн танхимыг түгээмэл дурдсан. Судалгаанд хамрагдсан ХБИ эдгээр сургалтад 7 хоногт 1-3 удаа орвол хамрагдах боломжтой байна. Ингэхдээ ижил төрлийн хөгжлийн бэрхшээлтэй, мэргэжлийн хүнээс сургалт, зөвлөгөө авах нь илүү үр дүнтэй гэдгийг дурджээ. Мөн Фэйсбүүк дээр богино хэмжээний видео хичээлийг байрлуулбал хэрэгтэй гэсэн саналыг хэлсэн.



Шигтгээ 5.

... Компьютер болон гар утасны талаарх сургалтууд мэдээж хэрэгтэй байх. Сүүлийн үеийн ухаалаг утсан дээр voice-ийг ашиглаад бүгдийг хийдэг болсон. Түүнийг хэрхэн зөв ашиглаж сурах талаарх сургалт байж болно. Мөн компьютерын программ дээрхийг хэрхэн ажиллаж сурах талаарх сургалт мөн байж болно. Мөн банкны үйлчилгээний аппликэйшнуудыг хүртээмжтэй байлгахын тулд мөн яаж ашиглах вэ? гэдэг тал дээрх тэрхүү чиглэлийн ерөнхийдөө интернэт орчинд хэрхэн яаж ажиллах гэдэг чиглэлийн сургалтууд хэрэгтэй байх. Миний ойлголтоор тэрхүү сургалтыг зөвхөн хараагүй хүмүүс хараагүй иргэддээ зааж чадна гэж харж байна. Өөр хүмүүс заана гэдэг маш учир дутагдалтай гэж харж байгаа. Яг энэ талаар хараагүй хүмүүст яг зааж сургаж чаддаг тийм мэргэжлийн хүмүүс заавал мөн арай илүү үр дүнтэй байна байх.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хийсэн ярилцлагаас

3




АХМАД НАСТАЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР



3. АХМАД НАСТАЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР

Ахмад настай иргэд (АНИ)-ийн цахим хүртээмж, ур чадвар орхигдож болохгүй асуудлын нэг юм. Шинэ технологийг амьдралдаа нэвтрүүлэх, хүлээж авах чадавх нас ахих тусам буурдаг учраас АНИ цахим хөгжлөөс хамгийн их хоцрогдож, ашиг тусыг хүртэж чадахгүй бүлэг байгааг судалгааны үр дүнгээс харагдаж байна. Судалгаанд оролцсон нийт ахмадын түгээмэл дүр зургийг бид Балган гуайгаар төлөөлүүлж харуулж байна.

3.1. Ахмад настай иргэдийн хүн ам зүйн үзүүлэлт

	Нэр: Балдан	Сарын орлого: 845'178₮ - улсын дунджаас 44% бага
	Нас: 65	Сард интернэтэд гаргадаг зардал: 31'958₮
	Ам бүл: 5	Сард харилцаа холбоонд гаргадаг зардал: 44'563₮
	Хөдөлмөр эрхлэлт: Тэтгэвэрт	
Зонхилон хэрэглэдэг аппликэйшн:		  

3.2. Ахмад настай иргэдийн цахим хүртээмжийн байдал

Судалгаанд хамрагдсан бусад бүлгийн иргэдтэй харьцуулахад, Балган гуай гэртээ интернэт төхөөрөмжтэй, хүссэн үедээ интернэтэд орох боломжтой ажээ. Мөн гэрээс гадуур яваа тохиолдолд утсандаа дата авч хэрэглэдэг тухайгаа ярьж байв. Бусад бүлгийнхэнтэй харьцуулахад гэртээ компьютертой, гэвч түүнийгээ огт хэрэглэж чадахгүй гэж өөрийгөө үнэллээ.



Шигтгээ 6.

... Тэтгэвэрт гарахаасаа өмнө компьютер дээр хэрэглээний программ дээр ажилладаг байсан одоо бол үгүй, хэрэгцээ ч бас байхгүй юм.

АНИ-тэй хийсэн ярилцлагаас



Шигтгээ 7.

... Хүүхдүүд л компьютер ажиллуулдаг юмаа. Би бол ерөөсөө хэрэглэдэг ч гүй, чадах ч гүй.

АНИ-тэй хийсэн ярилцлагаас

Мөн тэднийх ухаалаг гар утас, товчлууртай утасны аль алиныг нь ашигладаг, ур чадвараа ч боломжийн сайн гэж үнэлж байна. Гэр бүлийн гишүүн бүр ямар нэгэн төхөөрөмж ашигладаг тул төхөөрөмжийн хэрэгцээ байхгүй.

Балган гуай өдөр болгон интернэтэд ордог бөгөөд нэг орохдоо ойролцоогоор 3 цаг болдог. Үүнд Фэйсбүүкээ шалгаж, хүүхдүүдтэйгээ ярилцах, банкны гүйлгээ хийх, e-баримт дээр баримтуудаа шивэх зэргийг хийдэг. Хааяа гадаад мэдээ, эрүүл мэндийн мэдээлэл зэргийг олж унших дуртай.

КОВИД-19 цар тахлын үед түүний интернэт хэрэглээ төдийлөн нэмэгдээгүй. Онлайн үйлчилгээ амар хялбар, цаг хэмнэдэг гэж үздэг ч, өөрөө бие дааж хийж чаддаггүй учраас төрийн болон бусад үйлчилгээг өөрийн биеэр очиж авах сонирхолтой байдаг. Түүнчлэн интернэт уддаг, тасардаг, интернэт болон цахим үйлчилгээг хэрэглэх зааврууд ойлгомжгүй байдаг нь үйлчилгээг үргэлжлүүлэх авах, хэрхэн хэрэглэх, ямар асуудал гарсныг мэдэх боломжгүй болгодог байна.



Шигтгээ 8.

... Цахимаар үйлчилгээ авахад маш олон үйлдэл хийдэг, онлайнаар үйлчилгээ авах гэсэн боловч үйлчилгээ нь онлайн биш байдаг (Ковид-19-ийн хариу маш их хүлээлгэсэн)

АНИ-тэй хийсэн ярилцлагаас



Шигтгээ 9.


... Юнившний төлбөр төлөх болгонд орж ирдэг бонус оноог хэрхэн ашиглах гэхээр ойлгодоггүй болохоор ерөөсөө ашиглаж чаддаггүй.

АНИ-тэй хийсэн ярилцлагаас

3.3. Ахмад настай иргэдийн цахим ур чадвар

Балган гуай цахим ур чадварын 5 үзүүлэлт дээр нийт 4 оноо авахаас бүх үзүүлэлт дээр хангалтгүй буюу 2.7 болон түүнээс доош оноо авсан байна. Эдгээрээс цахим орчинд аюулгүй байдлаа хангах ур чадвар 1.6 буюу хамгийн муу, мэдээлэл хайж, олж авах чадвар (1.8), бусадтай хамтран ажиллах, харилцах ур чадвар 2.1 байгаа нь ХБИ-ийн эдгээр үзүүлэлт дээр авсан онооноос бүгд бага байгаа нь анхаарал татахуйц үр дүн байв.


Зураг 10. Ахмад настай иргэдийн цахим ур чадварын нэгдсэн үр дүн



3.3.1. Мэдээлэл хайж олж авах ур чадвар

Балган гуай зөвхөн Фэйсбүүкийг л итгэлтэй ашиглаж чаддаг бөгөөд интернэтээс хэрэгтэй мэдээллээ хайж, олж авч чаддаггүй, хэрэгцээ шаардлага үүссэн үед хүүхдүүд, эсвэл ойр дотны бусад хүмүүсийн туслалцааг авдаг. Фэйсбүүкээр гарч ирсэн мэдээллийг интернэтийн мэдээлэл гэж үздэг бөгөөд ихэвчлэн засгийн газрын хуралдаан, шийдвэр, цар тахлын талаарх мэдээлэл, хүнсний ногоо, ургамал тариалалт арчилгаа, уран зохиол, сонирхолтой түүх зэргийг уншиж үзэх дуртай. Мөн холбоосын дагуу худалдаа хийдэг.

Зураг 11. Ахмад настай иргэдийн мэдээлэл хайж олох ур чадвар



“

Шигтгээ 10.

... Онлайнаар юм захиалаад авхад цаг хэмнэдэг ч гэсэн яг өөрөө үзэж харж авсанаас шал өөр байдаг.

Ахмад настай иргэдийн төлөөлөлтэй хийсэн ФБЯ-аас

Харин өөрт таалагдсан, хэрэгтэй гэж бодсон бичвэр, зураг, хөгжим, дүрсийг яаж хадгалах, эргээд хаанаас олохоо мэдэхгүй байна. Хэдийгээр цахимаар тархаж буй мэдээлэл болгон үнэн биш гэдгийг мэддэг боловч, мэдээллийн эх сурвалж, найдвартай байдлыг шалгадаггүй.

“

Шигтгээ 11.

... Онлайнаар худалдан авалт хийхэд янз бүрийн л зүйлс шаардлагатай байдаг. Жишээ нь хүмүүс зальлуулдаг, хулхидуулдаг зөндөө л зүйлс тохиолддог. **Тэгэхлээр үүн дээр яг итгэлтэй газар юу байдаг талаар зөвөлгөө зөвлөмж заавар шаардлагатай байдаг.** Үнэхээр баталгаатай онлайн худалдаа мөн үү гэх мэт...


АНИ-ийн төлөөлөлтэй хийсэн ФБЯ-аас

3.3.2. Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар

Балдан гуайн хувьд бусадтай харилцахдаа ихэвчлэн дуудлага хийдэг ба тодорхой түвшинд текст мессеж бичдэг ч латин үсгээр текст мессеж бичих, уншиж чадахгүй тохиолдол үүсдэг байна. Фэйсбүүк мессенжер дээр видео дуудлага хийдэг боловч, цаад хүн нь залгасан тохиолдолд хялбар байдаг. Өөрөө бие дааж “видео колл” хийх, сошиал орчинд групп чат үүсгэж чаддаггүй тул хүүхдүүдээсээ, эсхүл бусдаас тусламж авч хийдэг байна.

Тэрээр нийгэм, улс төрд өрнөж буй асуудлаар өөрийн үзэл бодол санааг цахим орчинд төдийлөн илэрхийлээд байдаггүй, зүгээр уншаад л өнгөрдөг. Балган гуайтай харьцуулахад эмэгтэйчүүд илүү олноор коммент бичих, лайк дарах, шейр хийдэг юм байна.

Зураг 12. Ахмад настай иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар



“

Шигтгээ 12.

... Өөрийнхөө үзэл бодлыг бусдад тулагддаггүй ээ. Мөн янз бүрийн худал зүйлс рүү ордоггүй, өөрөө мөн худал мэдээлэл тараадаггүй ...

АНИ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

“

Шигтгээ 13.


... Ер нь Фэйсбүүкийг ажлын зорилгоор ашигладаггүй шүү дээ...

АНИ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

3.3.3. Цахим контент бүтээх ур чадвар

Балдан гуай болон түүний насны иргэд гар утсаараа бичлэг хийх, зураг авах зэрэг үйлдлийг дийлэнх нь өөрийн түвшинд хийж чаддаг ч тэдгээрт өөрчлөлт хийх, хувиргах чадамж сул байсан ба уг хийсэн бичлэг, зургаа бусдад илгээж чаддаггүй, хийж үзээгүй иргэд дийлэнх нь байсан нь судалгааны даалгавар хэсэгт харагдсан. АНИ-ийн хувьд контент бүтээх ур чадвар хэсэгт насны болон хүйсийн ач холбогдол бүхий ялгаа байхгүй байв.

Зураг 13. Ахмад настай иргэдийн цахим контент бүтээх ур чадвар




Түүний хувьд зураг авах, видео бичлэг хийх, аудио бичлэг хийх зэргийг ашиглаад ямар нэгэн контент бүтээж түүнийгээ хэрэглэж сурахаас илүүтэйгээр зураг авч сурах, видео бичлэг хийж сурах, сошиал орчинд сайн суралцах нь чухал байгаа нь судалгаанаас харагдсан.

3.3.4. Цахим аюулгүй байдлаа хангах чадвар

Балдан гуай төхөөрөмж болон интернэт орчны мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал дээр муу байгаа нь судалгаанаас харагдсан. Тэр гар утас, хэрэглэж буй төхөөрөмжийнхөө нууц үгийг дийлэнх нь сольж чадахгүй бөгөөд солих шаардлагагүй гэж үздэг байна. Гар утас, төхөөрөмж, хамгийн их хэрэглэдэг аппликейшн, нийгмийн сүлжээн дэх хаягийн нууц үгний ерөнхий бүтэц ямар байх ёстой, хэрэгцээ, ач холбогдлыг интернэт ашигладаг АНИ ерөнхийдөө гадарладаг боловч түүнийг хэрэгжүүлж чаддаггүй, хэрэгжүүлэх сэдэлгүй байна.

Зураг 14. Ахмад настай иргэдийн цахим аюулгүй байдлаа хангах ур чадвар



Балдан гуайн хувьд зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дуу, кино, бичлэг зэргийг үзэх, хуулбарлан тарааж болдоггүй талаарх мэдлэг, мэдээлэл хангалттай байдаг боловч зохиогчийн зөвшөөрөлтэй үгүйг хэрхэн мэдэх талаар дэлгэрэнгүй ярилцлага хэсэгт огт дурдаагүй байна. Нөгөө талаар манай улсад зохиогчийн

эрхийг хүндэтгэн үзэх, хэрхэн таньж мэдэх талаар хангалттай мэдээлэл байдаггүйтэй холбоотой.


Мөн судалгааны даалгавар хэсэг дэх гар утасны нууц кодоо солих, хамгийн их хэрэглэдэг аппликейшний нууц үгээ солих даалгавар АНИ-ийн хувьд хүндрэлтэй байсан боловч цахим орчин дах хувийн мэдээллийн талаар мэдээлэл боломжит хэмжээнд мэдэж байгаа ч уг мэдлэг, мэдээллээ интернэт орчинд хэрэгжүүлж чадахгүй байгаа нь АНИ-ийн цахим хэрэглээний ур чадвартай холбоотой байна. Гар утасны нууц үг, бусад шаардлагатай нууц үг солих хэрэгцээ гарвал хүүхдүүдээсээ дэмжлэг авах, тэдгээрээр хийлгэх байдлаар асуудлыг шийдвэрлэдэг.

3.3.5. Асуудлыг шийдвэрлэх ур чадвар

Балдан гуай болон цөөн тооны ахмадуудад гар утас, төхөөрөмж болон интернэт ашиглахтай холбоотой хүндрэлүүд үүсдэг бөгөөд уг хүндрэлд гар утсаа бүрэн ашиглаж чадахгүйгээс, гэрэл болон дууны тохиргоог тохируулах, дугаар хадгалалт болон түүнтэй холбоотой асуудлууд, мессеж унших, Англи хэлний асуудлуудаас болж хүндрэл үүсдэг байна.

Судалгаанд хамрагдсан дийлэнх ахмадуудын хувьд утсааны бүрэн хэрэглэж чаддаггүй учраас гар утас, төхөөрөмж хэрэглэхтэй холбоотой асуудал тулгардаггүй, эсвэл ямар асуудал тулгарч байгаагаа төдийлөн анзаардаггүй байна. Ямарваа нэгэн асуудал үүссэн тохиолдолд АНИ хамгийн түрүүнд хүүхдүүдээсээ эсхүл бусдаас тусламж авч шийдвэрлэдэг байна.

Зураг 15. Ахмад настай иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар



Балган гуайн хувьд социал орчинд бараг ордоггүй тул энэ талаарх ойлголт бага, асуудал бэрхшээл үүсдэггүй гэж үзэж байна. Харин социал аккаунт хэрэглэдэг АНИ-ийн хувьд хамгийн их тулгардаг асуудал бол хэлний мэдлэг буюу Фэйсбүүкийн цэсүүд, зарим тайлбаруудыг ойлгодоггүй нь хүндрэлтэй асуудал болдог байна.

Зураг 16. Цахим хэрэглээтэй холбоотой үүсдэг асуудлыг шийдвэрлэлт










Гар утастай холбоотой асуудал шийдвэрлэлт	Интернэтийн асуудал шийдвэрлэлт	Сошиал хаяг удирдахтай холбоотой асуудал
<ul style="list-style-type: none"> Хүүхдүүдээсээ эсхүл бусдаас туслалцаа авах Асааж унтраах үйлдэл хийх Холбоотой лавлахаас асуух 	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүдээсээ асуух эсхүл бусдаас туслалцаа авах Асааж унтраах Салбарт очих 	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүдээсээ эсхүл бусдаас туслалцаа авах Хэлний асуудлаас хамааран толь бичиг харах (1 хариулт)

Балган гуай болон түүний үеийн иргэдийн дийлэнх нь гар утас болон бусад төхөөрөмж, интернэтийн үйлчилгээ авахтай холбоотой тулгардаг бэрхшээлээ шийдвэрлэх сонирхолтой байдаг бөгөөд үүнд гар утас, интернэтийн ерөнхий мэдлэгээ сайжруулах сургалт хэрэгтэй байна гэж үзсэн байна. Нөгөө талаар гол бэрхшээл нь төхөөрөмж, интернэт нь англи хэл дээр учир хэлний бэрхшээл үүсдэг, Монгол хэл дээрх заавар, интернэт нь ойлгомжгүй байдаг зэрэг асуудлууд байна.

3.4. Ахмад настай иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ

Балган гуай болон түүний үеийн иргэдийн хувьд цахим хэрэглээ төдийлөн өргөн, их биш ч цахим ур чадвараа нэмэгдүүлэх сонирхолтой ахмадуудын хувьд цаашид гар утасны тохиргоог өөрсдөө бүрэн ажиллуулж сурах, төрийн үйлчилгээг цахимаар авах, аппликейшн суулгаж сурах зэрэг нь чухал, ач холбогдолтой, хэрэгцээтэй байгаагаа илэрхийлсэн байна. Нийт шаардлагатай хэрэгцээтэй байгаа сурах чиглэлүүдийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. Ахмад настай иргэдийн хувьд хэрэгцээтэй байгаа цахим ур чадварууд

	Ур чадвар	Эрэмбэ (чухлын зэргээр)
	Утасны тохиргоог бүрэн ажиллуулж сурах	I
	Видео колл хийж сурах	II
	Зураг авч, эвлүүлж зургийн цомог хийж сурах	III
	Видео бичлэгийн эвлүүлж сурах	III
	Аппликейшн татаж сурах	IV
	Төрийн үйлчилгээ онлайнаар авч сурах	IV
	Хэрэгцээтэй зүйлээ интернэтээс хайж сурах	V
	Онлайн худалдан авалт хийж сурах	V
	Төхөөрөмж болон интернэттэй холбоотой асуудал үүсэхэд шийдвэрлэх чадварт суралцах	V

Ахмад настай иргэдийн хувьд дээр дурдсан цахим ур чадварын хэрэгцээндээ зориулсан сургалтыг танхимаар авах сонирхолтой байна. Хорооны иргэдийн танхимд сургалтыг зохион байгуулахыг АНИ илүүд үзэж байна. Ингэхдээ сургалтын материалыг хэвлэмэл байдлаар гаргах нь сургалтын үр дүнг нэмэгдүүлнэ гэж үзэж байна. Судалгаанд хамрагдсан АНИ эдгээр сургалтад 7 хоногт 1 удаа хамрагдах боломжтой байна.

4


АЛСЛАГДСАН БҮСЭД
СУУРЬШИЖ БУЙ
ИРГЭДИЙН ЦАХИМ
УР ЧАДВАР



4. АЛСЛАГДСАН БҮСЭД СУУРЬШИЖ БУЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР

Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн хувьд “давхар хүчин зүйлийн цахим хуваагдал”-д өртөх эрсдэлтэй байдаг. Нэг талаас хотын зах болон хөдөөгийн өрхүүдэд өндөр хурдны интернэтийн дэд бүтэц хөгжөөгүй. Нөгөө талаас эдгээр бүсэд суурьшдаг иргэд, ялангуяа орлого багатай иргэд шаардлагатай тоног төхөөрөмж байдаггүй нь эрсдэлийг илүү нэмэгдүүлэх хүчин зүйл болдог¹⁵. Энэ нь судалгаанд хамрагдсан алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийг Болдоор төлүүлсэн юм.

4.1. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд






Нэр: Болд

Нас: 43

Ам бүл: 5

Хөдөлмөр эрхлэлт:
Малчин

Зонхилон хэрэглэдэг аппликэйшн:

Сарын орлого: 774'250₮ - улсын дунджаас 50% бага

Сард интернэтэд гаргадаг зардал: 25'154₮

Сард харилцаа холбоонд гаргадаг зардал: 56'000₮

4.2. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим хүртээмжтэй байдал

Болдын хувьд нийтлэг тулгарч буй бэрхшээл нь интернэтийн хурд, сүлжээний асуудал байна. Болдын гэр бүлийн гишүүд тус тусын ухаалаг утастай ч компьютер, таблет өрхийн гишүүдийн хэрэгцээнд ялангуяа хүүхдүүдийн хичээл хийхэд хүрэлцээгүй байна. Тиймээс Болдын хүүхдүүдэд хичээлийн хөтөлбөрөөсөө хоцрох, даалгавраа хийх нөхцөл муутай байна.

Болд болон Болдтой адил алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн хувьд интернэтийг тогтмол бус шаардлага гарсан дата авч интернэт ашигладаг. Тиймээс интернэтэд холбогдсон байдал харилцан адилгүй байна. Байнгын интернэттэй болоход санхүүгийн бэрхшээл, дэд бүтэц хөгжөөгүй газар оршин суудаг нь хамгийн том саад болдог байна.

Хүснэгт 6. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн интернэтийн хэрэглээ

	Бэрхшээл
Давтамж	<ul style="list-style-type: none"> 7 хоногт 1-3 удаа
Үргэлж хугацаа	<ul style="list-style-type: none"> Хувийн харилцаа холбоо Сурч боловсрох Мэдээлэл авах
Бэрхшээл	<ul style="list-style-type: none"> Сүлжээ муу Гадаад хэлний бэрхшээл (Англи хэл)
Хэрэгцээ	<ul style="list-style-type: none"> Мал, ноос ноолуурын үнэ ханш харах Дэлхий дахины мэдээлэл авах (вакцины талаарх бодит мэдээлэл авах) Интернэт банкаар гүйлгээ хийх Ажил хайх

Болд гар утас ашиглах чадвараа “боломжийн” харин компьютер ашиглах чадвараа “муу” гэж үнэлсэн. Гар утсандаа аппликейшн татаж чадахгүй байх тохиолдол нийтлэг ба тэр үедээ гэр бүлийнхнээсээ голчлон дэмжлэг авч байна.

Дээр дурдсанчлан Болд Фэйсбүүк, и-баримт, банкны аппликейшнуудыг хамгийн түгээмэл ашигладаг. Фэйсбүүкийг хүмүүстэй харилцах, хүүхдүүдийнхээ хичээл хийлгэх, мэдээлэл авах зорилгоор ашигладаг. Харин и-баримтыг баримт шивж оруулах, халамжийн мэдээлэл авах зорилгоор, банк аппликейшныг мөнгөн гүйлгээ хийх, дансны мэдээлэл авах зэргээр ашиглаж байна.

Болдын хувьд интернэтийн хурдны асуудал, цахим орчинд ажиллах ур чадвар зэрэг нь цахимаар үйлчилгээ авахад саад болдог тул төрийн үйлчилгээг ихэвчлэн биечлэн очиж авдаг байна.



Шигтгээ 14.


... Цахимаар үйлчилгээ авахад цаг хэмнэнэ, мэдээллийг хурдан авдаг. Сая вакцины сертификат авсан. Гэвч нууц код нэхээд төвөгтэй байдаг бас хэлийг нь мэддэггүй учраас бүрэн ашиглаж чаддаггүй.

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ярилцлагаас

4.3. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим ур чадвар

Цахим ур чадварыг 5 үзүүлэлт дээр харвал алслагдсан бүсэд оршин суудаг иргэд цахим орчноос мэдээлэл авах ур чадвар (2.3) болон цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар (2.4) хамгийн сул байна. Харин бусадтай харилцах, цахим контент бүтээх, асуудлыг шийдвэрлэх ур чадвар дээр 3-аас дээш оноо авсан ч сайжруулах шаардлага их байна.


Зураг 17. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим ур чадвар



4.3.1. Мэдээлэл хайж олох ур чадвар

Болд цахимаар өөрт хэрэгтэй мэдээлэл олж авах чадвараа “харьцангуй сайн” гэж үнэлж байгаа ч мэдээлэл авч буй суваг нь Фэйсбүүкээр хязгаарлагдаж байна. Болд мэдээллийн найдвартай байдалд ач холбогдол төдийлөн өгдөггүй учир найдвартай байдлыг шалгадаггүй байна. Харин интернэтээс харсан мэдээллээ олох чадвартай гэж өөрийгөө үнэлж байна. Болд ба түүний гэр бүлийн гишүүдээр даалгавар гүйцэтгүүлж үзэхэд хүйсээс хамаарсан ялгаа ажиглагдаагүй. Харин тэдний гадаад хэлний мэдлэг, ялангуяа Англи хэлний мэдлэг нь хүссэн мэдээллээ олж авахад хамгийн их саад болж байна.

Зураг 18. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн мэдээлэл хайж олох ур чадвар



Болд интернэтээс эрүүл мэнд, танин мэдэхүй, хүүхдийн хүмүүжил, хичээл, нийгэм, улс төрийн мэдээллийг нийтлэг авч байна. Мөн мал аж, ахуйтай холбоотой мэдээллүүд буюу малын бүтээгдэхүүний үнэ ханш, эм тарианы үнэ зэргийг хардаг байна.

Болд интернэтээс олсон мэдээллийнхээ үнэн бодит, найдвартай эсэхийг шалгадаггүй ба “энэ талаар бодож байгаагүй”, “үнэн л гэж боддог” гэсэн хариултуудыг өгсөн байна. Гэхдээ Болдын саахалт айлууд дунд худал мэдээлэл, тэдгээртэй холбоотой эх үүсвэрийн талаар ойлголттой хүмүүс цөөн ч гэсэн байна.

Шигтгээ 15.

... Хуурамч эх үүсвэр нь тодорхойгүй мэдээллийн сайтууд их байдаг. Мэдээллийн үнэн зөв байдлыг шалгахад хэцүү, их эргэлзээтэй байдаг.

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ФБЯ-ын оролцогчийн ярилцлагаас

Болд өдөр тутмын хэрэгцээндээ гар утас, компьютерыг ашиглаад дараах зүйлсийг хийж сурах хэрэгцээ байна. Үүнд:

- Интернэтээр хүссэн мэдээллээ олж чадах чадвар (цаг агаар, эмийн жор, оёдол эсгүүр, хоолны жор, нийгэм, эдийн засгийн асуудлууд)
- Банкны аппликейшнуудыг сайн ашиглаж сурах
- Англи хэлээ сайжруулах

Шигтгээ 16.

... Фэйсбүүкээр ихэвчлэн нийгэм, эдийн засгийн талаар мэдээлэл авдаг. Бүх зүйл интернэт цахимаар явдаг болсон үед хэлний бэрхшээл л их тулгардаг. Хэлийг өөрөө интернэтээр бие дааж судалдаг ч тодорхой мэдлэг өгөх багшийн чиглүүлэг их чухал байдаг. Сургалтыг танхимаар цөөн хүнтэй орвол илүү үр дүнтэй. Хүмүүс бие биенээсээ суралцаад илүү үр дүнтэй. Хотын захад асуудал их байна. Хүргэлтийн үйлчилгээ ирдэггүй. Хүүхдээ салхилуулах талбай байхгүй. Үйлчилгээний төвүүд хүртээмж багатай. Зам дагуу л ихэвчлэн байрладаг, зах руу байдаггүй. Хотын төвд ажиллаад оройтоход нийтийн тээвэр зогссон байдаг. Таксинд мөнгөө өгөх хэрэгтэй болдог. Гудам нь гэрэлтүүлэггүй. Хүмүүс гэрээсээ ажиллая, суръя гэсэн ч гэрт нь шаардлагатай компьютер төхөөрөмж байдаггүй. Утсаараа л ихэвчлэн интернэт ордог.

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ярилцлагаас

4.3.2. Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар

Болд бусадтай харилцах, хамтран ажиллах чадвараа “боломжийн сайн” хэмээн үнэлсэн байна. Болд ба түүний гэр бүлийн гишүүд бусадтай ямар ч бэрхшээлгүйгээр мессеж, чатаар харилцаж дуудлага, видеогоор харилцаж байна.




Шигтгээ 17.

... Цахим технологийн ачаар байршил харгалзахгүй хүссэн хүнтэйгээ харилцах боломжтой болсон нь сайхан юм. Миний хувьд гадаадад суугаа охинтойгоо цаг алдалгүй холбоо тогтоож чаддаг. Мөн хүүхдүүдийнхээ багштай групп чатаар холбогдож мэдээлэл авдаг.

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ФБЯ-ын оролцогчийн ярилцлагаас

Болд болон Болдын ойролцоо амьдардаг иргэд нийгмийн сүлжээнд улс төр, нийгмийн асуудлаар өөрсдийн үзэл бодлоо харилцан адилгүй илэрхийлж байна. Үзэл бодлоо постоор илэрхийлдэг иргэд насны хувьд 40-өөс дээш байсан ба судалгаанд хамрагдсан хамгийн залуу хоёр респондент буюу 19, 22 настай иргэн нийгмийн сүлжээнд үзэл бодлоо постоор огт илэрхийлдэггүй гэж хариулсан байсан нь сонирхол татаж байв.

Зураг 19. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар



Харин нийгмийн сүлжээнд бусдын орон зайг хүндэтгэн, биеэ зөв авч явах талаар Болд өөрийгөө “ойлголттой” хэмээн үнэлсэн. Болд цахим орчинд хүний нэр төрд халдах, дайрч давшлах үйлдэл түгээмэл байгаад шүүмжлэлтэй хандаж байгаа нь Болд энэ талын ойлголт, мэдлэгтэй болохыг харуулж байна.



Шигтгээ 18.

... Интернетээр олон төрлийн үйлчилгээг нэг дор авдаг болж байна. Гэхдээ энэ нь хоёр талтай байна. Нэг талаараа хүний нэр төрд маш их халддаг болсон. Мөн аливаа зүйлийн учрыг нь олоогүй, ойлгоогүй байж яаран дүгнэлт хийдэг, хэн нэгийг маш муухайгаар доромжилж өнгөц дүгнэлт хийж бие биенийгээ даган дуурайж муу зүйл рүү маш их шуурдаг. Сайн тал нь мэдээллийг түргэн шуурхай авч байна.


Алслагдсан өрхүүдтэй хийсэн ФБЯ-ын оролцогчийн ярилцлагаас

4.3.3. Цахим контент бүтээх ур чадвар

Болд өөрийн зураг, бичлэгийг аваад бусадтай хуваалцаж чадаж байна. Харин авсан зураг, бичлэгийнхээ өнгө, хэлбэр, хэмжээг өөрчлөх, өөр зурагтай нэгтгэж чадахгүй байна. Дээрхтэй холбоотойгоор зураг, бичлэгийг эвлүүлж сурах, хүүхдүүдэд зориулсан цахим контент бүтээх зэрэг хэрэгцээ байна. Болдын ойр орчимд цахим контент бүтээх чадвараа хөгжүүлэх, суралцах сонирхолгүй иргэд цөөнгүй байна. Эдгээр иргэдийн ур чадвар бага ч цаашид цахим контент бүтээж сурах нь ажил, амьдралд нь хэрэгцээгүй гэж үзэж байна.

Цахим орчинд бусдын дуу болон бичлэгийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах нь хууль бус зүйл болох талаар Болд өөрийгөө “ерөнхийдөө мэдлэгтэй” гэж үнэлсэн.

Зураг 20. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн цахим контент бүтээх ур чадвар



Шигтгээ 19.

... Ажлын маркетинг, сурталчилгааны реклам хийж сурмаар байна. Ийм чадвартай байхад хаана ч ажил хийгээд мөнгө олох боломжтой. Бас Фэйсбүүкээс гадна инстаграм, тик, ток зэрэгт зургаа аятайхан янзлаад оруулж сурах гэх мэт бүгдийг л сурмаар байна.

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ярилцлагаас

4.3.4. Аюулгүй байдлаа хангах ур чадвар

Болд цахим орчинд аюулгүй байдлаа хамгаалах чадвараа “боломжийн сайн” гэж үнэлсэн ч даалгавар гүйцэтгэх үед өөрийн утасны нууц нууц үг бусад хүмүүс таахад хэцүү байх ёстой гэдгийг “бага зэрэг гадарлана” хэмээн өөрсдийгөө үнэлсэн ч утсандаа нууц үг хийж, цоожилдоггүй байна. Дийлэнхдээ утсандаа нууц үг ашигладаггүй, утасныхаа нууц үгийг жил ба түүнээс дээш хугацаатайгаар сольдоггүй гэж хариулсан.




Шигтгээ 20.

... Утасны нууц үгээ өөрийн утасны дугаараар оруулсан. Огт сольдоггүй.

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ярилцлагаас

Зураг 21. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар



Болд өөрийн гар утас, төхөөрөмжийнхөө нууц үгийг бие даан сольж чадах чадвар дутмаг байна. Үүнд, утасны тохиргоог өөрчлөхөд хэлний мэдлэг шаардагддаг тул бэрхшээл болдог байна. Харин цахим орчинд өөрсдийн гэр бүлийн мэдээлэл, хүүхдүүдийн зураг, ажил эрхлэлтийн байдал зэрэг хувийн мэдээллээ хуваалцах нь аюултай гэж үзэж байна. Тиймээс гадны халдлагаас хувийн мэдээллээ хамгаалах ур чадваруудад суралцах хэрэгцээ байна. Үүнд, Фэйсбүүкийн тохиргоонуудыг сурах, гадны халдлагаас хамгаалах тохиргоог хийж сурах, хувийн аккаунтыгаа нууц үгийг сольж сурах, Фэйсбүүкээр орж ирдэг хэрэгтэй, хэрэггүй зүйлсийг блок хийж сурах зэрэг хэрэгцээг нэрлэсэн байна.



Шигтгээ 21.


... Цахим орчинд өөрийнхөө аюулгүй байдлыг хангахтай холбоотой нууц үгээ солих, хадгалах, и-мэйл шинээр үүсгэх зэрэг гадны халдлагад өртөхгүй байх бүхий л ур чадваруудад суралцмаар байна.

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ярилцлагаас

4.3.5. Асуудлыг шийдвэрлэх ур чадвар

Болд утасныхаа гэрэл болон дууг нэмж, хасах үйлдлийг бүгд гүйцэтгэж чадсан ба ингэхдээ зөвхөн зориулалтын товчлууруудаас гадны төхөөрөмжийн тохируулга хийдэг хэсэг рүү орж өөрчилж чадаж байна. Болдын хувьд утас ашиглахтай холбоотой тулгарч буй нийтлэг бэрхшээлүүдэд хэлний бэрхшээл, төхөөрөмжийг бүрэн ажиллуулах мэдлэг, чадвар дутмаг байх, дата дуусах, интернэтийн хурд удаан байх, гацах бэрхшээлүүд багтаж байна. Болд гар утас, интернэт ашиглахтай холбоотой ямар нэгэн бэрхшээл тулгарахад ихэвчлэн гэр бүлийнхнээсээ дэмжлэг авдаг ба ховор тохиолдолд өөрсдөө асуудлыг шийдвэрлэх гэж оролддог. Энэ нь төхөөрөмжийг унтрааж, асаах үйлдлээс хэтрэхгүй байна.

Зураг 22. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар



Хүснэгт 7. Алслагдсан бүсэд суурьшдаг өрхүүдэд гар утас, интернэт, нийгмийн сүлжээ ашиглах тулгардаг нийтлэг бэрхшээлүүд

	Бэрхшээл	Шийдвэрлэдэг арга зам
Гар утас ашиглахтай холбоотой	<ul style="list-style-type: none"> Хэлний бэрхшээл Төхөөрөмжийг бүрэн ажиллуулах чадвар, мэдлэг дутагдах 	<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн гишүүдээс дэмжлэг авдаг Өөрсдөө шийдэхийг оролддог
Интернэт ашиглахтай холбоотой	<ul style="list-style-type: none"> Интернэтийн хурд бага байх Сүлжээ унах Санхүүгийн асуудал (дата дуусах) 	<ul style="list-style-type: none"> Арга хэмжээ авах боломжгүй байдаг. Утасны дата хангалттай тохиолдолд гэр интернэтээс арай хурдан ажилладаг
Нийгмийн сүлжээ ашиглахтай холбоотой	<ul style="list-style-type: none"> Сүлжээ муу байх Групп чат үүсгэж чадахгүй байх 	<ul style="list-style-type: none"> Шийдвэрлэж чаддаггүй

4.4. Алслагдмал бүсэд суурьшдаг иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ

Фокус бүлгийн ярилцлагаар алслагдсан бүсэд суурьшдаг иргэдээс интернэт, компьютер, гар утас ашиглаад хийж сурахыг хүсэж буй зүйлсийг эрэмбэлүүлсэн. Алслагдсан бүсэд амьдарч буй иргэдийн хувьд санхүүгийн үйлчилгээ авахад банкны аппликейшныг ашиглах чадвар, хэрэгтэй мэдээллээ өөрсдөө олж авах чадвар, аюулгүй байдлаа хамгаалах чадварын хамгийн чухал гурван цахим ур чадварт тооцсон байна. Харин бусад чадваруудыг жигд сайн байх ёстой гэж үзсэн.

Хүснэгт 8. Алслагдсан бүсэд суурьшдаг иргэдийн интернэт, компьютер, гар утастай холбоотой чадваруудын ач холбогдол, өөрсдийн үнэлгээгээр

	Ур чадвар	Эрэмбэ (чухлын зэргээр)
	Утасны тохиргоог бүрэн ажиллуулж сурах	I
	Харилцах (видео дуудлага, олон хүнтэй зэрэг харж дуудлага хийх г.м)	II
	Санхүүгийн үйлчилгээ авах (мобайл банк хэрэглэх)	III
	Аюулгүй байдлаа хамгаалж сурах (залилангаас хамгаалах г.м.)	III
	Программууд дээр ажиллаж сурах (зураг янзлах, шивэх, бичлэг хийж янзлах, Word, Excel г.м)	IV
	Өөрт тулгарсан жижиг гэмтэл, гацалтыг шийдэж чаддаг болох	IV
	Апп суулгах, компьютерын программ суулгах	V
	Төрийн үйлчилгээ авах (и-баримт, и-Монголиа)	V
	Онлайн дэлгүүр үйлчлүүлэх	V
	Хэрэгтэй мэдээллээ хайх, олж авах	V

Алслагдсан бүсэд амьдардаг иргэдийн хувьд цахим ур чадварын хэрэгцээндээ зориулсан сургалтыг танхим, интернэтээр видео хичээл байдлаар, гарын авлага, сургалтын материалаар дамжуулан иргэдэд хүргэх боломжтой гэсэн олон талт саналууд гарсан. Сургалтад 14 хоногт 1 удаа орвол хамрагдах боломжтой байна. Зарим иргэдийн хувьд хорооны байр хол байдаг тул очиход хүүхдээ орхиод гарахад хүндрэлтэй гэсэн хариултыг өгсөн.



Шигтгээ 22.


... Компьютер ажиллуулах, интернэтэд орох, онлайн орчинд үйлчилгээ авах талаар сургалтад суувал зүгээр байна. Ойрхон газар хороон дээр компьютерын талаар сургалт болбол сууна. Компьютерын талаар мэргэжлийн хүн сургалт хийвэл зүгээр байна.

...Өөрөө бүгдийг нь мэддэг болмоор байна./мэргэжлийн сургалтын төв дээр хийвэл сайн хороон дээр бол худлаа нэг өдөр ирээд нэг өдөр ирэхгүй алга болчихдог мэргэжлийн багшаар 14 хоногийн сургалт авмаар байна./

Алслагдсан өрхүүдтэй хийсэн ФБЯ-ын оролцогчийн ярилцлагаас

5

ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР




5. ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР

Шилжин ирэгчдийн хувьд төрийн үйлчилгээнээс орхигдох, үйлчилгээ авч чадахгүй байх магадлал өндөр байдаг. Шилжин ирэгчдийн хувьд төрийн үйлчилгээнээс орхигдох, үйлчилгээ авч чадахгүй байх магадлал өндөр байдаг. Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагын тодорхойлолтоор шилжин ирэгч өрх гэдэг нь 3 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцсон, шилжих суурьшсан газар нутагтаа ядаж 180 ба түүнээс дээш хоногоор оршин сууж байгаа өрхийг хэлдэг. Эдгээр өрх шилжин суурьшаагүй өрхтэй харьцуулахад өөрийн эзэмшлийн орон байр, газартай байх нь бага ба ажил олох хүндрэлтэй байдаг¹⁸. Энэ нь цаашлаад эдгээр өрхүүд санхүүгийн хувьд интернэт, ухаалаг төхөөрөмж ашиглах боломж, бололцоо бага байх нөхцлийг бүрдүүлдэг.

Судалгаанд хамрагдсан шилжин ирэгчэд компьютер, гар утсыг ажиллуулахдаа хүүхдээсээ, бусдаас тусламж авдаг ч дийлэнх нь ухаалаг утас ашиглах ур чадвар боломжийн харин ур чадварын хувьд АНИ-ийн судалгааны үр дүнтэй ойролцоо байна. Судалгаанд оролцсон нийт ШИӨГ-ний түгээмэл түр зургийг Баясгалангаар төлөөлүүлэн харуулж байна.

5.1. Шилжин ирэгчдийн хүн ам зүйн үзүүлэлт



Нэр: Баясгалан

Нас: 33

Ам бүл: 5





Хөдөлмөр эрхлэлт:
Ажилтай (хагас цаг)

Сарын орлого: 1'419'231₮ - улсын дунджаас 5.4% бага

Сард интернэтэд гаргадаг зардал: 28'455₮

Сард харилцаа холбоонд гаргадаг зардал: 47'000₮

Зонхилон хэрэглэдэг аппликэйшн:

5.2. Шилжин ирэгчдийн цахим хүртээмжийн байдал

Баясгалан болон гэр бүлийн бүх гишүүд ухаалаг утастай, утасгүй интернэтээр болон гар утсандаа дата авч интернэт ашигладаг. Өрхийн гишүүд ихэвчлэн дата авч интернэт ордог учраас өрхийн бүх гишүүдэд интернэт ашиглах санхүүгийн бололцоо дутдаг байна. 7 хоногт дунджаар 4-өөс дээш болон шаардлагатай тохиолдолд хэзээ ч интернэтэд орох боломжтой байдаг. Өрхийн санхүүгийн боломж муу байгаагаас шалтгаалан бүгд компьютер хэрэглэх хэрэгцээ байв ч гишүүдэд хүрэлцэхүйц хэмжээний компьютер байхгүй учир өрхийн гишүүд ээлжилж, дундаа ашигладаг нэг компьютертой.

Баясгалан болон түүний гэр бүлийнхэн ухаалаг утас ашиглах чадвараа “боломжийн сайн” гэж үнэлсэн. Компьютертой иргэд түүнийг ашиглах чадвар тодорхой хэмжээнд эзэмшсэн тул хүнээс тусламж авах шаардлага бага байна. Баясгалан гар утсандаа аппликэйшн суулгах гэх мэт төхөөрөмжүүдийг ажиллуулах чадварыг гэр бүлийнхэн дундаа хамгийн сайн эзэмшсэн тул хэрэгцээтэй үед аав, ээждээ гар утас, төхөөрөмж ажиллуулах, ашиглахад нь тусалдаг байна.

Баясгалангийн гэр бүл интернэт хэрэглэх хэрэгцээг дараах байдлаар тодорхойлсон. Хэрвээ интернэтэд холбогдоогүй гишүүд интернэт орох хэрэгцээ шаардлага гарвал ойр дотны хүмүүсийн гэрт нь очих эсвэл тэднийг гэрт нь ирэхээр ордог байна.

Хүснэгт 9. Интернэтийн хэрэглээ

	Интернэт хэрэглээ	Нэмэлт тайлбар
Давтамж	<ul style="list-style-type: none"> Өдөр бүр 	-
Үргэлжлэх хугацаа	<ul style="list-style-type: none"> Дунджаар 1 цаг 58 мин (10 минутаас 6 цаг) 	Нас харьцангуй өндөр иргэдийн хувьд интернэтэд нэг орохдоо 15 мин хүртэлх маш богино хугацаанд ордог байна.

Ашигладаг зорилго	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл авах • Ажил хийх • Хувийн харилцаа холбоо • Амралт, чөлөөт цаг • Төрийн үйлчилгээ 	-
Хэрэгцээ	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл авах • Ажил хийх 	Шилжин ирэгчдийн ажил мэргэжлийн болон өдөр тутмын үйл явдлын талаарх мэдээлэл авч байна.



Шигтгээ 23.

... Интернетээр үнэт цаас болон хувьцааны талаарх мэдээлэл, ипотека болон төрийн үйлчилгээний мэдээлэл авах, барилгын материалын үнэ ханш судлах, ажилтай холбоотой шаардлагатай мэдээллээ харах зорилгоор ашигладаг даа.

Шилжин ирэгч иргэний ярилцлагаас

Дээр харуулсанчлан Баясгалангийн гэр бүлийн гишүүдийн нас, хөдөлмөр эрхлэлтээс хамаарч хамгийн их ашиглагддаг аппликэйшнүүд ялгаатай байна. Тухайлбал Баясгалангийн хувьд банкны аппликэйшн болон онлайн зээлийн аппликэйшний хэрэглээ өндөр байхад, түүний аав, ээжийн хувьд Фэйсбүүкийн хэрэглээ бусад аппликэйшнаас харьцангуй өндөр байна.



Шигтгээ 24.

... Санхүүгийн хэрэгцээ гарвал онлайн зээлийн аппликэйшин ашиглан өөрт тохирох зээлийг авчирдаг.

Шилжин ирэгч иргэний ярилцлагаас

Баясгалангийн өрхийн гишүүдийн түгээмэл хэрэглэдэг аппликэйшн болон хэрэглээ

Хүснэгт 10. Түгээмэл ашиглаж буй аппликэйшн болон хэрэглээ

Аппликэйшн	Ашиглаж буй зорилго
	<ul style="list-style-type: none"> • Гүйлгээ хийх • Төлбөр төлөх • Нэгж авах • Гүйлгээний болон зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл харах
	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл авах • Ажлаа хийх • Хүүхдийн хичээл хийлгэх
	<ul style="list-style-type: none"> • Баримт шивж оруулах • КОВИД-19 QR код уншуулах


Баясгалан ямар нэгэн онлайн үйлчилгээг төвөггүйгээр авч чаддаг ч өмнө дурдсанчлан түүний аав, ээж онлайн үйлчилгээ авахдаа бусдын тусламжийг байнга авдаг нь тэдний хувьд төвөгтэй байдлыг үүсгэдэг байна. Учир нь аливаа онлайн үйлчилгээний бүртгэл үүсгэх, үйлчилгээ авах нь ойлгомжгүй, зарим тохиолдолд дараагийн алхам нь яг яах нь удаж ирдэг гэх мэт асуудлаас болдог байна.

Ковид-19 цар тахлын үеийн хөл хорио нь Баясгалангийн хувьд цахим үйлчилгээ, интернэтийн хэрэглээг нэмэгдүүлсэн ч амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөхөөр тааламжгүй санагдсан байна. Учир нь нийгмийн харилцаа, гарч орох боломжийг цахим үйлчилгээ хязгаарлаж байна гэж хэлсэн. Гэхдээ цаашид улам илүү цахимжих тул Баясгалан өөрийн цахим ур чадвараа нэмэгдүүлэх сонирхол өндөр байгаагаар ярилцлагын үеэр хэлж байлаа.

5.3. Шилжин ирэгчдийн цахим ур чадвар

Баясгалан болон түүний гэр бүлийн гишүүдийн хувьд мэдээлэл хайж, олж авах ур чадвар (2.4) болон аюулгүй байдлаа хангах ур чадвар (2.5) буюу хангалтгүй түвшинд байсан. Бусад чадварууд буюу асуудлыг шийдвэрлэх ур чадвар, бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар болон цахим контент бүтээх ур чадварууд дээр 3-аас дээш оноо авсан ч мөн л сайжруулах шаардлагатай байна.


Зураг 23. Шилжин ирэгчдийн цахим ур чадвар



5.3.1. Мэдээлэл хайх, олж авах ур чадвар

Баясгалан интернэтээс өөрийн хүссэн мэдээллийг авдаг бөгөөд мэдээллийн найдвартай байдлыг нягтлан шалгадаг ба интернэтээс харсан мэдээллээ дараа нь төвөггүй олж чаддаг. Харин Баясгалангийн аав, ээжийнх нь хувьд бол энэ чадвар сул байсан. Интернэтээс авч буй мэдээлэл нь насны бүлгээс хамааран өөр өөр байгаа боловч нийтлэгээр цаг үеийн мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл, ажил мэргэжилтэйгээ ойролцоо мэдээлэл авдаг ч Баясгалангийн хувьд хувь хүний ур чадвараа хөгжүүлэх талын мэдээлэл авах сонирхол их байна.


Зураг 24. Шилжин ирэгчдийн мэдээлэл хайх, олж авах ур чадвар



5.3.2. Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар

Баясгалан мессеж, чат, дуудлага, видео колл-ийг ашиглан өдөр тутмын цахим харилцааг оролцдог. Тэдний гэр бүлийн гишүүдийн хувьд аав, ээж нь чат групп үүсгэх, видео колл хийх зэрэг чадвар сул, өрхийн гишүүдийн гол цахим хэрэглээ нь Фэйсбүүк байна. Тэд нийгмийн болон улс төрийн асуудлаар өөрийн үзэл бодлоо идэвхтэй илэрхийлдэггүй ч таалагдсан постыг хувийн профайлдаа хуваалцах, лайк дарах зэргийг хийж байна.

Зураг 25. Шилжин ирэгчдийн бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар




Баясгалан сошиал орчинд өөрт таалагдахгүй мэдээлэл ямар нэгэн реакшн үзүүлдэггүй, хараад өнгөрдөг, өөрөөр хэлбэл бусдын орон зайг хүндэтгэдэг. Шаардлагатай, хэрэгцээтэй тохиолдолд сошиалын өөр аккаунт ашигладаг ба сошиал орчинд хувийн болон ажил мэргэжлийн ялгааг тодорхой хэмжээнд ялгадаг. Тэрээр Фэйсбүүкийг ажилдаа пост, зар оруулах, лайв хийх гэх мэт байдлаар ашиглахаас гадна Англи хэлний мэдлэгээ сайжруулан олон боломжуудыг нэмж сурах хүсэлтэй байна.

5.3.3. Цахим контент бүтээх ур чадвар

Баясгалан гар утсаараа зураг авах, бичлэг хийж өөрийн хүссэн өөрчлөлтийг хийн сошиал орчинд бусадтай хуваалцдаг бөгөөд энэ нь амьдралын нэг хэвийн үзэгдэл боловч хэрвээ аав, ээжид нь ийм хэрэгцээ гарвал туслахаас өөр аргагүй байдаг байна. Гэхдээ Баясгалан судалгааны явцад сошиал орчинд зохиогчийн эрх, оюуны өмчийн талаар ойлголт тааруу гэдгээ илэрхийлсэн.

Зураг 26. Шилжин ирэгчдийн цахим контент бүтээх ур чадвар



Шигтгээ 25.


... Дууны бичлэг дээр зураг оруулах гэх мэт зүйлсийг би охиноороо хийлгэдэг болохоор өөрөө хийж сурах хүсэлтэй байдаг. Жишээ нь зураг, бичлэг, текст, аудио зэргийг бүрэн ашиглаж видео хийж сурмаар байна.

Шилжин ирэгч иргэний ярилцлагаас

5.3.4. Аюулгүй байдлаа хангах ур чадвар

Баясгалан гар утас, компьютер болон их ашигладаг аппликэйшнийхээ нууц үгийг солих шаардлагын мэддэг, хэрэгцээтэй үедээ нууц үгийг хүн таахад хэцүү байдлаар сольж чаддаг. Харин түүний ах, эгч, эсхүл аав, ээжийн хувьд гар утасныхаа нууц үгийг солих сонирхолгүй байна. Учир нь утас, төхөөрөмжөө ашиглах бүртээ нууц үгээ солихоос төвөгшөөдөг байна. Тэдний гэр бүлийн дийлэнх нь нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хэрхэн хангах талаарх мэдлэг ерөнхийдөө сул байна.

Зураг 27. Шилжин ирэгчдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар




Баясгалан болон түүний гэр бүлийн гишүүдэд цахим орчинд аюулгүй байдлаа хангах ур чадвартай холбоотой Фэйсбүүк орчинд нууц үг, нууцлалтай холбоотой болон мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын чиглэлийн ерөнхий ойлголт авах хэрэгцээ байна.

5.3.5. Асуудлыг шийдвэрлэх ур чадвар

Баясгалан өөрийн гар утасны тохируулгыг өөрт тохируулан өөрийн түвшинд өөрчлөн хэрэглэдэг ба их хэрэглэдэг аппликэйшнийхээ нууц үгийн мөн сольж хэрэглэдэг ч өөрийн хамааралтай өөрөөсөө ахмад настай хүмүүст туслах хэрэгцээ гардаг.

Зураг 28. Шилжин ирэгчдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар



Баясгалан өөрийн гар утасны тохиргоог сайн хийж чаддаг ба тулгарсан асуудлыг дараах байдлаар шийдвэрлэдэг байна.












Зураг 29. Цахим хэрэглээтэй холбоотой үүсдэг асуудлыг шийдвэрлэлт

Гар утастай холбоотой асуудал шийдвэрлэлт	Интернэтийн асуудал шийдвэрлэлт	Сошиал хаяг удирдахтай холбоотой асуудал
<ul style="list-style-type: none"> Ажиллагаа гацах, унтрах - Цэнэглэх, унтрааж асаах 	<ul style="list-style-type: none"> Интернэтийн хурд удаан - Ойр дотны хүмүүсээс асуух, дата авах 	<ul style="list-style-type: none"> Цэс, функцийг нь бүрэн ашиглаж чадахгүй байх

5.4. Шилжин ирэгчдийн цахим ур чадварын хэрэгцээ

Баясгалангийн болон түүний гэр бүлийн гишүүдийн цахим ур чадварын хэрэгцээ, шаардлага насны бүлгээс хамаарч өөр өөр байна. Түүний гэр бүлийн хэрэгцээг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 11. Шилжин ирэгчдийн хувьд хэрэгцээтэй байгаа цахим ур чадварууд

	Ур чадвар	Эрэмбэ (чухлын зэргээр)
	Өндөр хурдны интернэттэй болох	I
	Компьютер илүү ашиглаж сурах	II
	Онлайн орчинд ажиллах сурахтай холбоотой сургалтад суух	III
	Видео колл хийж сурах	III
	Зураг авч, эвлүүлж зургийн цомог хийж сурах	IV
	Видео бичлэгийн эвлүүлж сурах	IV
	Аппликейшн татаж сурах	V
	Төрийн үйлчилгээ онлайнгаар авч сурах	V
	Хэрэгцээтэй зүйлээ интернэтээс хайж сурах	V
	Онлайн худалдан авалт хийж сурах	V
	Төхөөрөмж болон интернэттэй холбоотой асуудал үүсэхэд шийдвэрлэх чадварт суралцах	V

Шилжин ирэгчид дээр дурдсан цахим ур чадварын хэрэгцээндээ зориулсан сургалтыг танхимаар том танхимд өргөн хүрээг хамруулан хийх; видео хичээл бэлтгэн онлайнд байршуулах; гарын авлага бэлтгэн хүмүүсийн хамгийн их очдог байршлуудаар тараах эсвэл онлайнд байршуулуулах сонирхолтой байсан. Сургалт, мэдээлэл авах арга хэмжээний давтамжийн хувьд сардаа нэг удаа байх нь тэдэнд тохиромжтой гэж үзсэн.

6





АМЬЖИРГААНЫ
БАТАЛГААЖИХ
ТҮВШИНГЭЭС ДООГУУР
ОРЛОГОТОЙ ИРГЭДИЙН
ЦАХИМ УР ЧАДВАР



6. АМЬЖИРГААНЫ БАТАЛГААЖИХ ТҮВШИНГЭЭС ДООГУУР ОРЛОГОТОЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАР

Ковид-19 цар тахлаас үүдэн Хүүхдийн мөнгө, Хүнсний эрхийн бичгийн тэтгэмжийг нэмсэн нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдралтай өрхийн орлого өсөхөд нөлөөлсөн ба бусад бүлгийн дундаж орлогоос өндөр байна.

6.1. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд

	Нэр: Дулмаа	Сарын орлого: 1'373'750₮ - улсын дунджаас 5.4% бага
	Нас: 34	Сард интернэтэд гаргадаг зардал: 38'091₮
	Ам бүл: 7	Сард харилцаа холбоонд гаргадаг зардал: 58'631₮
	Хөдөлмөр эрхлэлт: Түр ажилтай	
Зонхилон хэрэглэдэг аппликэйшн:		  

6.2. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн цахим хүртээмжийн байдал

Дулмаа 7 ам бүлтэй өрхийн гишүүн. Өрхийн сарын дундаж орлого 1,373,750 төгрөг, түүнээс 58,361 төгрөгийг харилцаа холбоонд, 38,091 төгрөгийг интернэтэд зарцуулдаг буюу энэ нь өрхийн орлогын 7%-ийг эзэлж байна.

Дулмаагийн өрхийн орлого бага тул өрхийн гишүүдийн хэрэгцээнд хүрэлцэхүйц гар утас, компьютер худалдан авч, ашиглаж чадахгүй байна. Дулмаа болон Дулмаатай ижил амьжиргааны түвшин бага иргэдийн хувьд ажил, хөдөлмөр эрхлэх нь бага байдаг тул цаг зав ихтэй, интернэтийг өдөр бүр тодорхой цагийн хязгаарлалтгүйгээр ашиглаж байна. Хэдий тийм боловч ашиглаж буй аппликэйшн нь Фэйсбүүкээр хязгаарлагдаж байна. Фэйсбүүкийг мэдээлэл авах, бусадтай харилцах, хүүхдүүдийнхээ хичээлийг хийлгэхэд голлон ашиглаж байна. Өрхийн гишүүдийн ажил эрхлэлт, нас, хүүхэдтэй эсэхээс хамааран ялгаатай аппликэйшнуудыг ашиглаж байна. Жишээлбэл, хүүхэдтэй ээжүүд хүүхдийнхээ хичээлтэй холбоотой мэдээлэл олох, багш нартай нь харилцах зорилгоор интернэтийг ашиглаж, залуу хүмүүс тоглоом тоглох, онлайн худалдаа хийх зэргээр ашиглаж байна.



Шигтгээ 26.

... Онлайнаар үйлчилгээ авахад заримдаа алдаа заадаг нь бэрхшээлтэй санагддаг. Төрийн үйлчилгээ авахад сайтын алдаа ихэвчлэн заадаг.

АБТДӨӨ-ийн иргэнтэй хийсэн ярилцлагаас


Дулмаа нь төрийн үйлчилгээг онлайнаар авах нь цаг хэмнэж, хурдан шуурхай байдаг, оочирлож зогсохгүй амар байдаг гэж үзэж байна. Гэвч Дулмаатай ижил орлого, амьжиргааны түвшинтэй иргэд төрийн үйлчилгээг биечлэн очиж авсаар байна. Төрийн үйлчилгээг онлайнаар авахад тулгардаг бэрхшээлүүдэд мэдээллүүд ойлгомжгүй байх, мэдээлэл бүрэн биш байх тохиолдлууд багтаж байна.

6.3. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн цахим ур чадвар

Дулмаагийн цахим ур чадварыг 5 үзүүлэлт дээр харвал нийт 4¹⁹ оноос авахаас цахим орчноос мэдээлэл авах ур чадвар (2.6) болон цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар (2.9) хамгийн сул байна. Бусад үзүүлэлт дээр 3-аас дээш оноо буюу харьцангуй өндөр оноо авсан.

¹⁷ Ур чадварын үнэлгээ 1-рүү дөхөх тусам тухайн ур чадвар муу, 1-тэй тэнцүү бол тухайн ур чадвар огт хангагдаагүй, 4-рүү дөхөх тусам ур чадварын үнэлгээ сайн, 4-тэй тэнцүү бол тухайн ур чадвар бүрэн хангагдсан гэж үзнэ. Тухайн ур чадварыг бүрэн чаддаг бол 4, огт чаддаггүй эсвэл мэдэхгүй бол 1 гэдэг үнэлгээ өгнө, тэдгээрийн дундаж үнэлгээгээр ур чадвар бүрийн эцсийн үнэлгээг гаргав.


Зураг 30. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн цахим ур чадвар



6.3.1. Мэдээлэл хайх, олж авах ур чадвар

Дулмаагийн хувьд мэдээлэл хайх, олж авах ур чадвар бусад зорилтот бүлгийн иргэдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Үүнийг цаг агаарын мэдээ зэргийг интернэтээс олох гэх мэт өгсөн даалгаврыг амжилттай гүйцэтгэж байгаагаас харах боломжтой байна. Харин цахим орчин дахь мэдээллийг найдвартай эсэхийг шалгаддаггүй, энэ талаарх ойлголт бага байна.

Зураг 31. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн мэдээлэл хайх, олж авах ур чадвар




Дулмаагийн хувьд интернэтээс харсан мэдээллээ дахин хайж олох чадвар хамгийн хангалтгүй байна. Үүнд Дулмаагийн Англи хэлний мэдлэг бага байгаа нь хамгийн их нөлөөлж байна.

6.3.2. Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар

Дулмаа цахимаар бусадтай харилцах, хамтран ажиллах чадварын хувьд бусад бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй сайн байсан. Тэрээр Фэйсбүүк мессеж, дуудлагыг маш сайн хийж, бусадтай тогтмол харилцдаг нь даалгаврын гүйцэтгэлээс харагдаж байв. Харин социал орчинд (Фэйсбүүк) дундын групп чат үүсгэх чадвар Дулмаагийн ээж болох ахмад настанд дутмаг байна.

Зураг 32. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн бусадтай харилцах, хамтран ажиллах үр чадвар



Дулмаа цахим орчинд нийгмийн болон улс төрийн асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлдэг. Ингэхдээ бусдын орон зайг хүндэтгэх, хэрэлдэж маргахгүй байх, доромжилсон болоод өөрийн үзэл бодлоо тулгасан өнгө аяс гаргахгүй байхыг хичээдэг байна.

Тэрээр цахим орчинд хувийн болон ажлын шугамаар ашиглахдаа ялгаатай дүр төрх үүсгэхээ мэддэг байна. Жишээлбэл, сүлжээний бизнес эрхэгчдийн группэдээ өөрийн бизнестэй холбоотой зүйлсийн талаар мэдээлэл солилцдог байна.



Шигтгээ 27.


... Би хувийн, ажил мэргэжлийн гэх байдлаар Фэйсбүүкээ ялгаж ашиглаж чаддаг гэж боддог. Жишээлбэл, AMWAY-н группүүд дотор, тэрнээс гадуур гээд өөр өөр байдлаар харилцаа үүсгээд явдаг.

АБТДӨӨ-ийн иргэнтэй хийсэн ярилцлагаас

6.3.3. Цахим контент бүтээх үр чадвар

Дулмаагийн хувьд зураг, бичлэг аваад, хэн нэгэн рүү илгээх чадвартай ч тэдгээрт өөрчлөлт оруулах, цахим контент бүтээх чадвар дутмаг байна.

Зураг 33. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн цахим контент бүтээх үр чадвар




Дулмаа болон түүнтэй ижил амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд ажилтайгаа холбоотой богино хэмжээний видео контент, сурталчилгааны самбар, анимэйшн зэрэг цахим контент хийж сурах сонирхолтой байна.

6.3.4 Аюулгүй байдлаа хангах ур чадвар

Дулмаа төхөөрөмжийнхөө нууц үг, пин кодоо бусад хүн таахад хэцүү байдлаар оруулах талаар сайн мэддэг ч төхөөрөмжийнхөө тохиргоог хэрхэн өөрчлөхөө мэдэхгүй тохиолдол гардаг байна.

Зураг 34. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн аюулгүй байдлаа хангах ур чадвар




Дулмаагийн хувьд мөн л хувийн мэдээллээ нийгмийн сүлжээнд хамгаалах хэрэгтэй гэдгийг гадарладаг ч мэддэг ч хэрхэн хамгаалах талаар сайн мэдэхгүй байна. Харин зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дуу, кино, бичлэг зэргийг үзэх хуулбарлан тараах нь хууль бус гэдгийг ерөнхийдөө мэдэж байна.

6.3.5 Асуудлыг шийдвэрлэх ур чадвар

Асуудлыг шийдвэрлэх чадварын хувьд Дулмаа ашиглаж буй төхөөрөмжийнхөө тохиргоог өөрчлөх чадвар сайн байгаа нь өөрийн үнэлгээ болон даалгавар гүйцэтгэхэд илэрч байна. Тэрээр утасныхаа дууг чангалж, суллах, дэлгэцийн гэрэл багасгаж, ихэсгэх даалгаврыг бүрэн гүйцэтгэсэн бол сүүлийн даалгавар болох банкны, Фэйсбүүк хаягийн, мэйлийн аль нэгэнд танаас өөр хүн нэвтэрсэн тухай мэдэгдэл утсанд нь ирэхэд хэн нэгнээс тусламж асуух болон шийдвэрлэх талаар мэдэхгүй байна.

Зураг 35. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн асуудлыг шийдвэрлэх ур чадвар








Тэрээр утастай холбоотой асуудал тулгарахад унтрааж асаах, хэн нэгнээс тусалцаа авах зэргээр шийддэг байна. Харин интернэт ашиглахтай холбоотойгоор хэлний бэрхшээл, интернэтийн хурдтай холбоотой бэрхшээл нийтлэгээр тулгардаг бөгөөд хэлтэй холбоотой асуудлаа хүнээс тусламж асуух болон Гүүгл Транслейт-ээр шийддэг бол интернэтийн хурдтай холбоотой асуудлаа дата авах, интернэт цацдаг төхөөрөмж солих зэргээр шийддэг байна.

6.4 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ

Дулмаагийн хүүхдийнхээ хичээлийг хийлгэх, тэдэндээ хэрэгтэй мэдээллийг хайх, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ ихтэй болохоор цахим хэрэглээ бусдаасаа харьцангуй өндөртэй. Гэртээ зөөврийн интернэт төхөөрөмжтэй, шаардлагатай үед гар утасны датагаараа интернэтэд ордог.

Хүснэгт 12. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувьд хэрэгцээтэй байгаа цахим ур чадварууд

	Ур чадвар	Эрэмбэ (чухлын зэргээр)
	Интернэт, компьютерыг бүрэн ашиглаж сурах	I
	Өөртөө болон гэр бүлийнхэндээ хэрэгцээтэй мэдээлэл олж авдаг болох	II
	Ажилтайгаа холбоотой контент хийж сурах	III
	Цахим орчинд гарсан асуудлаа өөрөө шийдэж чаддаг болох	III
	Цахим орчин дахь аюулгүй байдлаа хангах талаар сурах	III


Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувьд цахим ур чадварын хэрэгцээндээ зориулсан сургалтыг танхимаар хороон дээрээ, багш, мэргэжлийн хүнээр 7 хоногт 2 удаа авах нийтлэг хүсэл сонирхолтой байна. Сургалтын онцлогийн хувьд бүлгээр зохион байгуулах нь тэдэнд үр дүнтэй байна. Зарим иргэдийн хувьд хүүхдээрээ заалгах нь илүү үр дүнтэй гэж үзсэн. Үүний давуу тал нь хэрэгтэй үедээ мэдэхгүй зүйлээ, ганцаарчлан сурах, заалгах, асуудлаа шийдэхэд нь амар хялбар байх бөгөөд давтамжийн хувьд өдөр бүр заалгах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнг нэгтгэн танилцуулбал хүртээмжийн хувьд зорилтот таван бүлэгт гар утас, компьютерийн хүртээмж хангалтгүй байна. Дийлэнх өрхийн гишүүд бүгд гар утастай ч товчлууртай утасны хэрэглээ хэвээрээ байна. Түүнчлэн гэртээ компьютертэй айл маш цөөн, интернэт холбогдолт бага, ихэвчлэн шаардлагатай үедээ утсаараа дата авч интернэт ашиглаж байгаа зэрэг нь зорилтот бүлгүүдийн санхүүгийн чадамжгүй байдлаас шууд хамааралтай байна.

Харин судалгаанд хамрагдсан зорилтот таван бүлгээс **ахмад настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар бусад бүлгийн иргэдтэй харьцуулахад хамгийн бага байна** (Зураг 1). Бусад бүлгийн хувьд ухаалаг утас ашиглах мэдлэг чадвар ойролцоо нэг ижил түвшинд, ерөнхийдөө сайн байсан. Оролцогчдын цахим ур чадварын ялгаатай байдлыг хүн ам зүйн шинжээр нь харьцуулан үзвэл оролцогчийн хүйс болон тухайн төхөөрөмжийн хүртээмж (ашиглах боломжтой байдал) болон тухайн төхөөрөмжийг ашигласан жилийн туршлагаас хамаарсан ялгаа ажиглагдсан. Тодруулбал, эрэгтэйчүүдийн ухаалаг утас ашиглах мэдлэг, чадвар эмэгтэйчүүдийнхээс илүү байна. Мөн төхөөрөмжийг ашиглаж буй жил болон төхөөрөмжийн хүртээмжээс хамааран иргэдийн цахим ур чадвар ялгаатай байна.

Зураг 36. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ДижКомп аргачлалын хүрээгээр



Үнэлгээнд авч үзсэн 5 ур чадвараас цахим контент бүтээх буюу утсаараа зураг авах, бичлэг хийх, түүнийг өөрчлөн контент бүтээх чадвар нь нийт оролцогчдын дунд хамгийн өндөр байна. Бусад 4 чадварын хувьд тус бүрд 4 оноо авахаас бүгд 3-аас бага оноо авсан байгаа нь жигд хангалтгүй байгааг илтгэж байв.

Хүснэгт 13. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар, ур чадвар тус бүрээр, 1-4 хүртэлх онооноос

Зорилтот бүлгийн төрөл	Мэдээлэл хайх, олж авах ур чадварын дундаж үнэлгээ	Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадварын дундаж үнэлгээ	Цахим контент бүтээх ур чадварын дундаж үнэлгээ	Аюулгүй байдлаа хангах ур чадварын үнэлгээ	Асуудлыг шийдвэрлэх ур чадварын дундаж үнэлгээ
Ерөнхий дундаж үнэлгээ	2.2	2.9	3.0	2.3	3.1
Хөгжлийн бэрхшээлтэй	2.1	2.7	2.6	2.2	2.8
Өндөр настан	1.8	2.1	2.5	1.6	2.7
Амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрх	2.6	3.4	3.5	2.9	3.2
Шилжигч өрх	2.4	3.0	3.2	2.5	3.4
Хөдөөгийн/ алслагдмал өрх	2.3	3.1	3.3	2.4	3.4

*Ур чадварын үнэлгээ 1-рүү дөхөх тусам тухайн ур чадвар муу, 4-рүү дөхөх тусам ур сайн гэж үзнэ.

Оролцогчдын цахим ур чадварын ялгаатай байдлыг хүн ам зүйн шинжээр нь харьцуулан үзвэл оролцогчийн хүйс болон тухайн төхөөрөмжийн хүртээмж (ашиглах боломжтой байдал) болон тухайн төхөөрөмжийг ашигласан жилийн туршлагаас хамаарсан ялгаа ажиглагдсан. Тодруулбал, залуу оролцогчдын цахим орчинг сонирхох байдал, ур чадвар нь ахимаг насны оролцогчдоос илүү сайн байна. Өөр нэг ажиглагдсан зүйл нь эрэгтэйчүүд нийтдээ цахим хөгжил, үйлчилгээг дэмжсэн, эерэг хандлагатай байгаа боловч ухаалаг утас ашиглах бодит чадвар, сошиал орчингийн идэвх зэрэг нь эмэгтэйчүүдийнхээс доогуур байна. Эмэгтэйчүүд цахим үйлчилгээ болон сошиал орчинг идэвхтэй ашигладаг учраас төрөл бүрийн эерэг болон сөрөг туршлагаудыг хуримтлуулж байна. Жишээлбэл, тэд цахим халдлага, дайралт болон үнэн мэдээллээс ялгагдахгүй хуурамч мэдээлэлтэй таарах тохолдол элбэг байдаг. Үүнийхээ улмаас цахим орчингоос болгоомжлох хандлага ажиглагдлаа. Мөн төхөөрөмжийг ашиглаж буй жил болон төхөөрөмжийн хүртээмжээс хамааран иргэдийн цахим ур чадвар ялгаатай байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Түвшин	Санал, зөвлөмж	Хариуцах эзэн
Бодлого боловсруулах, батлах түвшинд	Хотын захын хороолол, хөдөөгийн өрхүүдэд чиглэсэн интернэт, сүлжээний дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж өгөх	УИХ, холбогдох яамд, ХХМТГ
Хэрэгжүүлэх түвшинд	Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай төсөв, санхүүжилтийг батлах	ХХМТГ
	2022 онд “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлэх, сургамж туршлага бүхий асуудлуудыг тодруулах замаар хугацаа алдалгүй дараагийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	ХХМТГ, ХЭГ, иргэний нийгмийн байгууллагууд
	Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаанд ашигласан арга зүй, сургамжийг ашиглан иргэдийн цахим ур чадварыг үнэлэх үндэсний судалгааг зохион байгуулах	ХХМТГ, YCG
	Сонсгол, харааны бэрхшээлтэй иргэдэд цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ авах нөхцөлийн бүрдүүлэх. Үүнд WCAG олон улсын стандартыг албан ёсоор Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2019 онд орчуулж гаргасан “Веб контентийн хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал” (-ыг ашиглах боломжтой. Энэ аргачлалын дагуу И-монголиа болон бусад төрийн, хувийн хэвшлийн үйлчилгээний сайтуудад үнэлгээ хийх, ХБИ болон бусад зорилтот бүлгийн иргэдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн сайт, аппликейшны хүртээмжийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах	ХХМТГ, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил
	Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгуулах. Агуулга нь тухайн бүлгээс хамаарч өөр байж болно. Жишээлбэл, ахмад настны бүлэгт хамгийн түгээмэл ашиглагддаг цахим хуудас, аппликейшныг ажиллуулах, гар утасны тохиргоог өөрчлөх гэх мэт тэдний сонирхолд нийцсэн сургалтын агуулгыг зааж болох юм	ХХМТГ, ХНХЯ-ны харьяа байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллага
	Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхдээ цахим төхөөрөмжгүй иргэдийн хэрэгцээг харгалзан үзэж уламжлалт хэлбэрээр авах хувилбарыг санал болгох. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломжтой ажлын байрны зарыг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох, цахим хичээлийг алслагдсан бүс, хөдөө амьдарч буй хүүхдүүдийн хэрэгцээг харгалзан үзэж, хэвлэмэл хувилбараар санал болгох гэх мэт.	ХНХЯ, БШУЯ, ажил олгогчид
	Иргэдэд цахим ур чадварын тухай нэгдсэн, ерөнхий ойлголтыг өгөх, ач холбогдлыг ойлгуулах. Жишээлбэл, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим мэдээллийн найдвартай байдлыг шалгах, цахим контент бүтээж сурах, ажил хөдөлмөр олох боломжоо нэмэгдүүлэх гэх мэт	ХНХЯ-ны харьяа байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд
	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд оролцуулахын ач холбогдлыг сурталчилж, тэдний гэр бүл, ойр дотны хүмүүсийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх	ХНХЯ-ны харьяа байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. Оролцогчдыг сонгох шалгуур үзүүлэлт

	Судалгаанд оролцуулах бүлэг	Тодорхойлолт	Судалгаанд хамруулах шалгуур үзүүлэлт
1	Өндөр настан	60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн ¹⁸	Ахмад настны тэтгэвэр авдаг байх
2	Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх	Ядуурлын шугамаас доош орлоготой нэг хүнд ногдох сарын хэрэглээ 279,912 төгрөгөөс доош хэрэглээний зардалтай өрх ¹⁹	Хүнсний эрхийн бичиг авдаг байх
3	Хөдөөгийн өрх	Нийслэл Улаанбаатар болон аймгийн төвүүд “хот” гэсэн ангилалд багтана. Харин бүх сум байршлын хувьд “хөдөө” гэсэн ангилалд хамаарагдана ²⁰ .	Хотын бүсээс гадна алслагдмал хороод болон Төв аймгийн оршин суугч байх
4	Шилжин суурьшигч өрх	Судалгаанаас өмнөх 3 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцсон, шилжих суурьшсан газар нутагтаа ядаж 180 ба түүнээс дээш хоногоор оршин сууж байгаа өрхийг “Шилжигч өрх” гэж үзнэ ²¹ .	Судалгаанаас өмнөх 3 сарын хугацаанд шинээр шилжиж ирж, бүртгэлээ хийлгэсэн байх
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх	“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно ²²	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь 50%-аас дээш чадвар алдалттай, хараа, сонсгол, хэл яриа, тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд байх

18 Ахмад настны тухай хууль, 3.1 дүгээр зүйл, 2017

19 ҮСХ-ны ӨНЭЭС-ны аргачлал, 2018

20 ҮСХ-ны ХАОСТ-ын аргачлал, 2018

21 ҮСХ-ны ХАОСТ-ын аргачлал, 2018

22 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016

ХАВСРАЛТ 2. Судалгаанд хамруулсан ХБИ-ийн бэрхшээлийн төрөл, үндэслэл, судалгаа авах аргачлал

Бүлэг	Тайлбар	Ярилцлага хийхэд анхаарах зүйлс
Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэд	Мэдээллийн хүртээмж бага байх магадлалыг харгалзан бүрэн сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй дараах байдлаар харилцдаг иргэдтэй ярилцлага хийхээр төлөвлөж байна. 1. Бүрэн дохионы хэлээр харилцдаг 2. Амны хайрцаг уншиж өөрийгөө дохио зангаа болон бичгээр харилцдаг 3. Бичгээр харилцдаг	Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн үгийн баялаг, нөөц хязгаарлагдмал байдгаас ярилцлага хийх явцад цахим тоног төхөөрөмж, дижитал мэдлэг чадвартай холбоотой асуулт болон бусад өгөх даалгавруудыг бүрэн ойлгохгүй байх эрсдэлтэй. Иймд ярилцлагыг IRIM судалгааны хүрээлэнтэй хамтарч ажилладаг мэргэжлийн дохионы хэлмэрч нартай хамтарч зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд гол нэр томъёо, үг хэллэгийг үзүүлэх зураг, бичиж харуулах цаас зэрэг нэмэлт хэрэгслүүд ашиглагдаж болно.
Харааны бэрхшээлтэй иргэд	Харааны сулралтай болон бүрэн хараагүй иргэдийг сонгох	Даалгавар өгч ажиллуулах гар утас, таблетын текст, дүрсийн хэмжээг ердийн хэмжээнээс том, контрастийг нь өндөр болгох
Тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд	Гар утас, компьютер цахим тоног төхөөрөмж ашиглах хязгаарлагдмал байдлыг харгалзан үе мөчний саажилттай, хөл гарын тайралттай иргэдийг сонгох	Ярилцлага хийх өрөөг сонгохдоо тэргэнцэр, таяг зэрэг хөдөлгөөний нэмэлт хэрэгсэл ашигладаг иргэдийг чөлөөтэй зорчих боломжтой зай талбайг харгалзана.

Судалгааны гол зорилго нь эдгээр бэрхшээлтэй иргэдийн цахим хэрэглээ, мэдлэг чадвар, цахим орчинд ажиллаж мэдээлэл авахад тулгардаг хүндрэл бэрхшээл, цаашид сайжруулах санал зөвлөмжийг боловсруулах зорилготой тул нийт ярилцлага хийхээр төлөвлөсөн 15 ХБХ-ийг дараах байдлаар сонгож судалгаанд хамруулахаар төлөвлөж байна. Үүнд:

- Хараа, сонсгол, тулгуур эрхтний бэрхшээлтэй (тархины саажилттай) иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-д ажилладаг ХБХ
- Төслийн сонгогдсон орон нутагт амьдардаг хараа, сонсгол, тулгуур эрхтний (тархины саажилттай) бэрхшээлтэй хүн

ХАВСРАЛТ 3. Хүн ам зүйн мэдээлэл /зорилтот бүлгээр/

		Зорилтот бүлгийн төрөл				
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх	Өндөр настан	Амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрх	Шилжигч өрх	Хөдөөгийн/алслагдмал өрх
Нийт судалгаанд хамрагдсан		16	16	16	14	16
Дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	31.3%	37.5%	50.0%	21.4%	31.3%
	Баянзүрх дүүрэг	43.8%	18.8%	31.3%	28.6%	18.8%
	Хан-Уул дүүрэг	25.0%	43.8%	18.8%	50.0%	43.8%
	Налайх	0.0%	0.0%	0.0%	0.0%	6.3%
Хүйс	Эрэгтэй	50.0%	50.0%	37.5%	42.9%	31.3%
	Эмэгтэй	50.0%	50.0%	62.5%	57.1%	68.8%
Нас	25 хүртэл настай	0.0%	0.0%	31.3%	14.3%	18.8%
	26-35 настай	18.8%	0.0%	37.5%	35.7%	6.2%
	36-45 настай	56.2%	0.0%	25.0%	21.4%	50.0%
	46-55 настай	25.0%	6.3%	6.2%	14.3%	18.8%
	56-аас дээш настай	0.0%	93.8%	0.0%	14.3%	6.2%
Боловсролын түвшин	Боловсролгүй	6.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%
	Бага (1-5)	12.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%
	Суурь (6-9)	6.3%	18.8%	0.0%	14.3%	12.5%
	Бүрэн дунд (10-12)	50.0%	37.4%	75.0%	64.3%	56.3%
	Техник мэргэжлийн дээд	12.5%	25.0%	12.5%	0.0%	12.4%
	Дээд	12.5%	18.8%	12.5%	21.4%	18.8%
Гэрлэлтийн байдал	Ганц бие	12.5%	6.3%	31.3%	28.6%	12.5%
	Гэрлэсэн	62.5%	37.5%	50.0%	42.9%	68.8%
	Хамтран амьдрагч	12.5%	6.3%	6.3%	7.1%	6.3%
	Салсан/Тусгаарласан	6.3%	0.0%	12.5%	21.4%	12.5%
	Бэлэвсэн	6.3%	50.0%	0.0%	0.0%	0.0%
Өрхийн гишүүдийн тоо	Ганц бие	0.0%	25.0%	0.0%	21.4%	0.0%
	2-3 гишүүн	56.3%	37.5%	6.3%	21.4%	31.3%
	4-5 гишүүн	37.5%	37.5%	37.5%	35.7%	56.3%
	6 ба түүнээс дээш	6.3%	0.0%	56.3%	21.4%	12.5%
Хөдөлмөр эрхлэлт	Байнгын ажилтай	25.0%	12.5%	50.0%	50.0%	43.8%
	Улирлын шинж чанартай ажилтай	6.3%	0.0%	0.0%	7.1%	6.3%
	Түр зуурын ажилтай (хагас цагийн хөдөлмөр, Ажил олдохоор хийдэг)	12.5%	0.0%	12.5%	28.6%	18.8%
	Ажилгүй	56.3%	6.3%	31.3%	14.3%	31.3%
	Тэтгэвэрт гарсан	0.0%	81.3%	6.3%	0.0%	0.0%
	Бусад	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%

ХАВСРАЛТ 4. Өрхийн утас, компьютерийн хэрэглээ /зорилтот бүлгээр/

		Зорилтот бүлгийн төрөл				
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх	Өндөр настан	Амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрх	Шилжигч өрх	Хөдөөгийн/алслагдмал өрх
Товчлууртай утасны тоо	Байхгүй	50.0%	75.0%	75.0%	50.0%	75.0%
	1	37.5%	0.0%	12.5%	21.4%	18.8%
	2	6.3%	12.5%	12.5%	28.6%	6.3%
	3	6.3%	12.5%	0.0%	0.0%	0.0%
Ухаалаг утасны тоо	Байхгүй	18.8%	12.5%	0.0%	0.0%	0.0%
	1	6.3%	25.0%	12.5%	21.4%	6.3%
	2	37.5%	18.8%	37.5%	35.7%	12.5%
	3	37.5%	18.8%	31.3%	7.1%	56.3%
	4	0.0%	12.5%	6.3%	28.6%	18.8%
	5	0.0%	12.5%	12.5%	0.0%	0.0%
	6	0.0%	0.0%	0.0%	7.1%	6.3%
Компьютерын тоо	Байхгүй	81.3%	68.8%	62.5%	71.4%	56.3%
	1	18.8%	25.0%	25.0%	28.6%	37.5%
	2	0.0%	0.0%	12.5%	0.0%	0.0%
	3	0.0%	6.3%	0.0%	0.0%	0.0%
	4	0.0%	0.0%	0.0%	0.0%	6.3%
Таблетын тоо	Байхгүй	100.0%	100.0%	93.8%	92.9%	93.8%
	1	0.0%	0.0%	6.3%	7.1%	6.3%
Товчлууртай утас ашигласан хугацаа		3	7	6	5	3
Ухаалаг утас ашигласан хугацаа		6	9	7	5	8
Компьютер ашигласан хугацаа		7	4	3	2	6
Таблет ашигласан хугацаа		N/A	N/A	3	1	1

ХАВСРАЛТ 5. Өрхийн утас, компьютерийн хүрэлцээ /зорилтот бүлгээр/

		Зорилтот бүлгийн төрөл				
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх	Өндөр настан	Амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрх	Шилжигч өрх	Хөдөөгийн/алслагдмал өрх
Нийт судалгаанд хамрагдсан		16	16	16	14	16
Танайд байгаа утас, компьютер зэрэг төхөөрөмж танай өрхийн гишүүдэд хэр хүрэлцээтэй байдаг вэ?	Огт хүрэлцдэггүй	0.0%	0.0%	18.8%	14.3%	0.0%
	Хүрэлцдэггүй	0.0%	6.3%	25.0%	7.1%	31.3%
	Боломжийн	62.5%	25.0%	31.3%	42.9%	43.8%
	Хангалттай	37.5%	68.8%	25.0%	35.7%	25.0%
Та гар утас, компьютероо ажиллуулахдаа хэнээс тусламж авдаг вэ? (олон сонголттой хариулт)	Хүүхэд	50.0%	68.8%	25.0%	61.5%	57.1%
	Ач/зээ	0.0%	25.0%	0.0%	0.0%	0.0%
	Гэр бүлийн бусад гишүүн, хамаатан	31.3%	6.3%	12.5%	15.4%	28.6%
	Гарын авлага, танилцуулга	0.0%	0.0%	0.0%	7.7%	0.0%
	Өөрөө сурсан	25.0%	6.3%	50.0%	15.4%	14.3%
	Найз нөхөд	0.0%	12.5%	18.8%	15.4%	14.3%
Ухаалаг гар утас хэр сайн ашигладаг вэ?	Огт ашигладаггүй	64.3%	62.5%	33.3%	28.6%	25.0%
	Маш муу	14.3%	0.0%	0.0%	0.0%	6.3%
	Муу	0.0%	18.8%	26.7%	42.9%	37.5%
	Боломжийн	21.4%	18.8%	33.3%	21.4%	25.0%
	Маш сайн	0.0%	0.0%	6.7%	7.1%	6.3%
Таблет хэр сайн ашигладаг вэ?	Огт ашигладаггүй	100.0%	93.8%	86.7%	78.6%	93.3%
	Маш муу	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
	Муу	0.0%	6.3%	6.7%	7.1%	6.7%
	Боломжийн	0.0%	0.0%	6.7%	14.3%	0.0%
	Маш сайн	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%

ХАВСРАЛТ 6. Өрхийн интернэтийн хүртээмж болон хэрэглээ /зорилтот бүлгээр/

		Зорилтот бүлгийн төрөл				
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх	Өндөр настан	Амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур амьдралтай өрх	Шилжигч өрх	Хөдөөгийн/алслагдмал өрх
Нийт судалгаанд хамрагдсан		16	16	16	14	16
Танай өрх интернэтэд холбогдсон уу?	Кабель (LAN) холболт	0.0%	0.0%	6.3%	0.0%	18.8%
	Wifi төхөөрөмж	18.8%	62.5%	37.5%	50.0%	25.0%
	Гар утасны интернэт	37.5%	12.5%	31.3%	28.6%	18.8%
	Холбогдоогүй	43.8%	25.0%	25.0%	21.4%	37.5%
Та интернэтийг ямар давтамжтай ашигладаг вэ?	Өдөр бүр	33.3%	60.0%	80.0%	61.5%	43.8%
	7 хоногт 4-өөс дээш	0.0%	6.7%	13.3%	15.4%	18.8%
	7 хоногт 1-3 удаа	66.7%	26.7%	6.7%	15.4%	31.3%
	Сардаа 4-өөс дээш	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
	Сардаа 1-3 удаа	0.0%	0.0%	0.0%	7.7%	0.0%
	Жилдээ цөөхөн удаа	0.0%	0.0%	0.0%	0.0%	6.3%
	Огт ашигладаггүй	0.0%	6.7%	0.0%	0.0%	0.0%
Та ажил хийдэг бол ажилдаа интернэт хэрэглэдэг үү?	Ажилдаа интернэт хэрэглэдэггүй	70.0%	66.7%	38.5%	50.0%	50.0%
	Хааяа	10.0%	0.0%	23.1%	25.0%	14.3%
	7 хоног тутам	10.0%	11.1%	7.7%	8.3%	0.0%
	Өдөр бүр	10.0%	22.2%	30.8%	16.7%	35.7%
Таблет хэр сайн ашигладаг вэ?	Төрийн үйлчилгээ	55.6%	40.0%	66.7%	20.0%	10.0%
	Ажил хийх	11.1%	0.0%	8.3%	30.0%	30.0%
	Хувийн харилцаа холбоо	33.3%	20.0%	58.3%	40.0%	40.0%
	Амралт чөлөөт цаг	11.1%	0.0%	25.0%	30.0%	30.0%
	Сурах боловсролын зорилгоор	33.3%	0.0%	58.3%	40.0%	30.0%
	Мэдээлэл авах	66.7%	20.0%	50.0%	40.0%	60.0%
	Бусад	0.0%	20.0%	0.0%	10.0%	0.0%
Та утсандаа аппликэйшн татаж авч чадах уу?	Тийм	37.5%	12.5%	93.8%	64.3%	75.0%
	Үгүй	62.5%	87.5%	6.3%	35.7%	25.0%

НҮБХХ-ийн хэвлэл
Судалгааг гүйцэтгэсэн баг: Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)

Холбоо барих хаяг:
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гудамж 14,
Сүхбаатар дүүрэг, 14201, Улаанбаатар хот,

Утас: +976-11-327585
Вэб хаяг: mn.undp.org
Twitter: [@UNDP Mongolia](https://twitter.com/UNDP Mongolia)
Facebook: [@UNDP in Mongolia](https://www.facebook.com/UNDP in Mongolia)- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
Instagram: [@undpmn](https://www.instagram.com/undpmn)